

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

100 YEARS

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

2024





АГУУЛГА

УДИРТГАЛ

Бидний тухай
ТУЗ-ийн даргын захидал
Гүйцэтгэх захирлын захидал

5
9
10

АПУ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

Баяржалт Монгол Тогтвортой хөгжлийн стратегийн хэрэгжилтийн эхлэл
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд
Гүйцэтгэлийн түгжүүр үзүүлэлтэд тусгасан байдал

15
17
18

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН 5 ХАНА

Ямагт орших өв соёл
Ногоон ба цэвэр тунгалаг
Хүчирхэгжсэн хамт олон
Баялаг ба харилцагатай
Тогтвортой түнш

21
25
37
43
47

ХАВСРАЛТ

Монголын Хөрөнгийн Биржийн Бонд-ын үйл ажиллагааны тайлан

57





01

УДИРТГАЛ

Бидний тухай
ТУЗ-ийн даргын захидал
Гүйцэтгэх захирлын захидал



ЭРХЭМ ЗОРИЛГО

ШИНЭ САНАЛ САНААЧИЛГА, БҮТЭЭХ
ТЭМҮҮЛЛЭЭР УРЛАЖ БУЙ БҮХЭНДЭЭ
ҮРГЭЛЖ СЭТГЭЛЭЭ ШИНГЭЭНЭ.

АЛСЫН ХАРАА

ДЭЛХИЙД ТАНИГДАХ ЭРХЭМ МОНГОЛ
ХҮМҮҮНИЙ ОЮУН ЧАДВАР, УР УХААН,
ШИНЭЧЛЭЛ, **ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН**
УНДАРГА БАЙЯ.

ҮНЭТ ЗҮЙЛС

ТАНИХ
ЭРМЭЛЗЭЛ

ЭРЭЛ, ХАЙГУУЛЧ СЭТГЭЭ

Тасралтгүй шинийг эрэлхийлж,
суралцаж, хуваалцаж, туршиж.

ҮНЭН
ЧАНАР

ХАМТДАА ЯЛЬЯ

Чанарыг эрхэмлэн, ялалтын
сэтгэлгээгээр урагшлах

БҮТЭЭЛЧ
ЧАДВАР

ИННОВАЦИЛАГ АЖИЛЛАЯ

Уламжлалаа хүндлэж, шинийг бүтээх

ХҮНЛЭГ
СЭТГЭЛ

ХҮНДЛЭН ЭРХЭМЛЭЭ

"Хүн" байхыг чухалчилж, сайн
сайхныг түгээх.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Цэвэржавын
ЭРДЭНЭБИЛЭГ
Гүйцэтгэн захирал



Данзарова
АРИУНА
Экспорт зэрэглсэн захирал



Балсайрны
ЦАЦРАЛ
Борлуулалт, маркетинг зэрэглсэн захирал



Жаргалсайханы
ИЧИНХОРЛОО
Захирагд, Хүний нөөц зэрэглсэн захирал



Добров
НИКОЛАЙ
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа зэрэглсэн захирал



Захвал
АЛЕШ
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа зэрэглсэн захирал




Гонимгийн
ЭНХБИЛЭГ
Санхүү зэрэглсэн захирал, Төслийн удирдлагын захирал



Гансүмдэвгийн
БАЯРМАГНАЙ
АПУ Дайри 100%-ийн Гүйцэтгэн захирал

АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ



*2024 онд АПУ Групп компанийн бүтэцд өөрчлөлт гароогүй

ТУЗ-ИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ

2024 он бол АПУ ХК-ийн хувьд түүхэн онцгой жил байлаа. Бид зууныг туулсан илтэг, хариуцлагын өвийг өнөө үеийнхээ бодит ажил, ирээдүйн зорилгоор бататгаж, 100 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлсэн жил болсон.

100 жилийн өмнө манай компанийг үүсгэн байгуулсан эрхэм хүмүүс тухайн цаг үеийн сорилт бэрхшээлийг даван туулж, Монгол Улсын хүнсний үйлдвэрлэлийн салбарт анхдагчийн үүргийг гүйцэтгэсэн билээ. Өнөөдөр тэдний үр хүүхдүүд ач зээ нар нь АПУ ХК-ийн хамт олны нэгэн хэсэг болон ажиллаж, энэ их өвийг улам хөгжүүлэн, дараа үедээ хариуцлагатайгаар залгамжлуулж байна. Энэ бол зөвхөн нэг компанийн түүх бус, олон гэр бүл, үе үеийн хөдөлмөр бүтээл, үнэт зүйлсийн нэгдэл юм.

Өнгөрсөн онд бид өмнөх амжилт, туршлагадаа тулгуурлан, илүү үр дүнтэй хэрэгжилт, илүү бодит өөрчлөлтөд төвлөрч ажиллалаа. Хамт олны маань хүчин чармайлт, шинэ хандлагын үр дүнд байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай үйлдвэрлэл, хамтын хөгжил, нийгмийн сайн сайханд чиглэсэн олон санаачилга бодит үр дүнгээ өгч эхэлсэнд бид баяртай байна.

Дараагийн 100 жилийн түүхийн хуудсаа эхлүүлэхдээ бид олон улсын жишигт нийцсэн, ногоон, хариуцлагатай үйлдвэрлэл байж, Монгол бахархлыг дэлхийн тавцанд гаргасан байгууллага байх зорилгоо тууштай үргэлжлүүлнэ.

Энэхүү аялалд бидэнтэй хамт байгаа эрхэм хэрэгжигч, хариуцлагч, хамт олон, хувьцаа эзэмшигч та бүхэндээ гүн талархал илэрхийлье.

Пүрэвийн Батсайхан

Batsaikhan



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

Бид 100 жилийнхээ ойг ёслол төгөлдөр тэмдэглэж, зууны турш хуримтлуулсан уламжлал, туршлага, итгэлцэл дээрээ тулгуурлан дараагийн зуун руу зоримгоор алхан орлоо.

Энэ жил бид "Бахархалт Монгол" Тогтвортой хөгжлийн стратегиа баталж, компанийн ирээдүйн хөгжлийг илүү хариуцлагатай, ил тод, ажилтан бүрийн оролцоог дэмжсэн чиглэлд тодорхойлж, Байгаль орчин, нийгэм, засаглалын чухал сэдвүүдийг бизнесийн үндсэн бодлого, шийдвэр гаргалтад системтэй нэгтгэж, стратегийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Салбарын тэргүүлэгчийн хувьд бид зөвхөн бүтээгдэхүүнээрээ биш, хэрэгтэгчид, ажилчид, харилцагчид болон орон нутгийн иргэд гээд бүх оролцогч талуудаа урт хугацааны үнэ цэнийг бүтээх хариуцлагатай байр суурийг баримталдаг билээ.

2024 онд бид:

- Тогтвортой хөгжлийн стратегийн 5 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх гол ажлуудыг тодорхойлон, байгууллагын бүх түвшинд нэгдсэн нэг ойлголт, чиглэлтэйгээр уялдуулах суурийг тавилаа.
- Хүлэмжийн хийн ялгарлыг анх удаа бүрэн хүрээнд тооцож, цаашдын зорилт, үйл ажиллагааг шинжлэх ухаанч, үр дүнд суурилсан байдлаар тодорхойлох боломжийг бүрдүүлээ.
- Ажилтнуудын сайн сайхан байдлыг дэмжих байгууллагын соёлыг гүнзгийрүүлж, тэгш хүртээмжтэй ажиллах орчныг бүрдүүлэх хандлагаа улам бэхжүүлэн ажиллаж байна.
- Хөгжлийн менежментийг системтэйгээр сайжруулах, дахин ашиглах, ангилан ялгах үйл явцыг боловсронгуй болгож чиглэлд тодорхой ажлуудыг эхлүүлсэн нь бидний байгаль орчинд хандах хариуцлагатай хандлагын илэрхийлэл юм.

Тогтвортой хөгжил бол бидний хувьд салангид хөтөлбөр биш, харин **бизнесийн ирээдүйн цорын ганц зөв зам** юм. Энэхүү замналд АТҮ гэр бүлийн гишүүн бүрийн оролцоо, хандлага хамгийн чухал үнэт зүйлсүүдийн нэг билээ.

Хамтдаа дараагийн 100 жилийг илүү хариуцлагатай, хамтач, үр өгөөжтэй байдлаар эхлүүлцгээе!

Цэвэрэнжавын Эрдэнэбилэг




Хамрах хүрээ 1
35,598.87 тн CO₂e

Хамрах хүрээ 2
47,839.24 тн CO₂e

Хамрах хүрээ 3 (Upstream)
245,764.7 тн CO₂e

Нийт хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ

404,693.39 тн CO₂e

Биогеник (ферментациас үүсэх) ялгарлын хэмжээ:
1,167.35 тн CO₂e

Хамрах хүрээ 3 (Downstream)
75,490.6 тн CO₂e

2024 ОН *Toогоор*



Нийт ажилтны тоо:
2402

Цахилгааны хэмнэлт
93.5 мега Втц

Дулааны хэмнэлт
34873 Гкал

Тарьсан мод
1500

Нарны эрчим хүчний үйлдвэрлэл
1160.8 кВтц

Усны хэмнэлт
17,658 м3

Дахин ашигласан болон дахин боловсруулсан хөг хаягдал
74.65%

Шил татан авах цэгүүд
700 гаруй

Нэг ажилтанд ногдох ХАБЭА танхимын сургалт
6.3 цаг

Нэг ажилтанд ноогдох сургалт
12.3 цаг

9348
Эмчийн үзлэг

2540
Булчин, судас, дусал, арьсан доорх тариа

8769
Бариа, бумба, шарлага

1120
Хүнсний үйлдвэрийн ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэг



АПУ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

Бахархалт Монгол: Тогтвортой хөгжлийн стратегийн хэрэгжилтийн эхлэл
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд
Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтэд тусгасан байдал

“БАХАРХАЛТ МОНГОЛ” ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЭХЛЭЛ

2024 он нь АГПВ ХК-ийн хувьд тогтвортой хөгжлийн институцилал, суурь чиглэлийн тодорхойлолт, цаашидын үйл ажиллагааны үндэс суурийг бүрдүүлэх онцгой жил байлаа. Өнгөрсөн онд эхлэлийг нь тавьсан “Бахархалт Монгол” Тогтвортой хөгжлийн стратеги 2030-ыг 2024 оны 7 сарын 23-нд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөрөө албан ёсоор батлав. Уг стратегийн хүрээнд бид байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөө 5 ханат нөлөөллийн гэр моделийн дагуу илүү нарийвчлан тодорхойлох, дотоод процесс, зорилтуудыг чиглүүлэх ажлуудыг эхлүүлээ.

2024 онд бид дараах үндсэн ажлуудыг хэрэгжүүлээд байна. Үүнд:

- Стратегийн хэрэгжилтийг чиглүүлэх гол үйл ажиллагаанууд болон тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон;
- Нөлөөллийн чиглэл тус бүрд төлөвлөх ажлын хүрээг гаргаж, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах эхлэл тавьсан;
- Хүлэмжийн хийн ялгарлын (Хамрах хүрээ 1, 2, 3) тооцооллыг анх удаа гүйцэтгэн, Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн (ҮТХН-буку NDC) зорилтод оруулах бодит суурийг бүрдүүлсэн;
- Оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх боломжуудыг судалж, дотоод үйл ажиллагаандаа нэгтгэх бэлтгэл ажлуудыг эхлүүлсэн.

Цаашид бид стратеги хэрэгжилтийн төлөвлөгөөг шат дараатайгаар хэрэгжүүлж, жил бүр ахиц дэвшлийг үнэлэх, ил тод тайлагнах, үндэсний тогтвортой хөгжилд бодит хувь нэмэр оруулахыг зорьж байна.



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД



ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮЛХҮҮР ҮЗҮҮЛЭЛТЭД ТУСГАСАН БАЙДАЛ

Тогтвортой хөгжлийн стратегийг батлахтай зэрэгцэн группийн хэмжээнд бүх алба, нэгжийг хамарсан ажлын хэсгийг байгуулж, 2027 он хүртэл стратегийн хэрэгжилтийг чиглүүлэх гол чиглэл, ажлын төлөвлөгөөг гаргасан билээ. Цаашлаад хариуцсан захирал, холбогдох ажилтнуудын ажлын төлөвлөгөөнд тусгагдав.

Ингэснээр группийн хэмжээнд тогтвортой хөгжлийн зорилго, зарчмуудыг үйл ажиллагаандаа шингээж, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэхийн тулд АПУ группийн **нэгдсэн стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг** болгон бодит үр дүнд хүрэхийг зорьж байна.

Дараагийн шатанд стратегийн хэрэгжилтийг **тогтмол хянаж, үнэлэх тогтолцоог бий болгож**, хариуцлагын хүрээг тодорхойлон, тайлагналын ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах болно.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН 5 ХАНА

Ямагт орших өв соёл
Ногоон ба цэвэр тунгалаг
Хүчирхэгжсэн хамт олон
Баялаг ба хариуцлагатай
Тогтвортой түнш

03





Зорилго:

Монгол үндэстний гайхамшигт өв соёлыг ямагт амьд байлгаж, хойч үедээ өвлүүлэн үлдээхэд АГУ ХК өөрийн бизнесийн практик, хамтын ажиллагаа, нөөц боломжоо бүрэн ашиглах байна.

Монголын уламжлалт өв соёлыг бүтээгдэхүүн, үйл ажиллагаагаараа дамжуулан түгээж, хойч үедээ өвлүүлэн үлдээхэд чиглэсэн "Ямагт орших өв соёл" хананы хүрээнд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, бэлтгэн нийлүүлэгчидтэйгээ тогтвортойгоор хамтран ажиллах зорилтуудын дагуу хийсэн ажлуудаа тайлагнаж байна.

НОГООН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

АГУ Дэйри Монгол сүүний үйлдвэрийн шинэ үйлдвэрийн бүтээн байгуулалтыг уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, тогтвортой, ногоон үйлдвэрлэлийн чиг баримжааг баримтгаж, эрчим хүчний хангамжийн шалгуурт нийцсэн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр үйл ажиллагаагаа явуулах боломжтой шийдлээр байгуулахаар зорьж АХБ болон ЕССХБ 50 : 50 хувиар санхүүжүүлснээр нийт 40 сая долларын гэрээг АГУ ХК, АГУ Дэйри Монгол сүүний үйлдвэртэй байгуулав.



АГУ компани сүүний салбарт ногоон үйлдвэрлэлийг эрчимжүүлэхээр Азийн Хөгжлийн Банк (АХБ) болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн банк (ЕССХБ)-тай 40 сая долларын хамтын санхүүжилтийн гэрээг байгууллаа.

Энэхүү санхүүжилтийн гэрээ нь хунс, хөдөө аж ахуйн салбарт ногоон үйлдвэрлэл, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр олон улсын томоохон хөгжлийн санхүүгийн байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран хийж буй ажлын хамтын ажиллагаа гэдгээрээ онцлогтой юм.

Сүү, сүүн бүтээгдэхүүний салбарт малчид, фермерүүдийн сүү нийлүүлэлтийг өсгөх, малчдын амьжиргааг дэмжих улмаар хүн амын эрүүл мэндэд ээлтэй сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд АГУ Дэйри Монгол сүүний үйлдвэрийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, өргөтгөх шинэ бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна.

Энэхүү төслийн хэрэгжилтийн хүрээнд бид ирэх гурван жилийн хугацаанд 700 малчдыг уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, түүний сүүний салбарт үзүүлэх нөлөө, дасан зохицох болон уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн арга барилын талаар үе шаттайгаар сургаж, чадавхижуулах ажлыг төлөвлөн байна.

Төслийн судалгааны шатанд 7 аймгийн 13 сумдаар 9000 км явж 500 гаруй малчидтай уулзалт хийв.

ОРОН НУТГИЙН ФЕРМЕР, МАЛЧДЫГ ДЭМЖИХ АЖЛУУД

Өдөр бүр хэрэглэгчдэд шинээрээ хүрэх бүтээгдэхүүнүүдийн гол түүхий эд болох сүү, цагаан идээ, эмийн ургамлыг бэлтгэн нийлүүлдэг малчид, фермерүүдээ дэмжин ажиллах нь бидний хариуцлага билээ.

Архангай аймгийн Чулуут сумын фермер, малчдын хувд нийт **138 сая төгрөгийн 18 тонн түүхий эд, бүтээгдэхүүн татан авсан** нь орон нутгийн эдийн засгийг дэмжих, тогтвортой худалдан авалтын бодлогыг хэрэгжүүлж буй бодит жишээ юм.

2024 онд

- Фермерүүдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор давхардсан тоогоор нийт 340 гаруй малчдад "Фермерийн сургалт, өдөрлөг"-ийг зохион байгууллаа. Энэ өдөрлөгөөр фермийн менежмент, малын арчилгаа, үхрийн тэжээлийг тохируулах, ашиг шим сайжруулах, малын өвчлөл түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, сүүний чанар, хадгалалт, стандарт, сайн туршлагын талаар мэдлэг мэдээлэл хуваалцан малчид фермерүүдийг чадавхижуулах ажлыг өрнүүлээ.
- Өвөлжилт хүндэрсэн Хэнтий, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Булган аймгийн сумдын сүү бэлтгэн нийлүүлдэг 400 гаруй малчдад өөс тэжээлийн тусламж үзүүлсэн.

Бид орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулахыг зорин дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна:

- Тогтвортой орлоготой ажиллах боломжийг бүрдүүлэх
- Шар айргийн үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн болох шавар ашиглан малын тэжээлээр хангах
- Мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтууд зохион байгуулах
- Орон нутгийн хөгжлийн санаачилгыг тасралтгүй дэмжих



ЭРҮҮЛ МАЛЧИН ХӨТӨЛБӨР

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх "НБЮ ЮНИ ХХК" -тай хамтран **2024 оны 8-р сарын 17 - 18-ны өдрүүдэд** Сэлэнгэ аймгийн Мандал сумын төв, Улаанбаатар хотын эргэн тойронд Тавантолгой, Шувуун фабрик Аргалант булгийн тохой, Батомьёор, Үдлэг, Партизан, 361-ийн гарам орчмын **5 байршилд** Эрүүл малчин хөтөлбөрийг зохион байгууллаа.

Хөтөлбөрийн хүрээнд нийт **424 малчид фермерүүдэд мэргэжлийн эмч нар үзлэг шинжилгээ хийн**, "Малын гаралтай өвчлөлөөс хэрхэн сэргийлэх, Хүний брүцеллээс өвчний талаар оношилгоо, урьдчилан сэргийлэлт, хяналт" сэдвээр мэргэжлийн **сургалт, зөвлөгөө өгөв**.

Үзлэгээр нийтлэг ажиглагдсан зүйл нь харилцагч малчид маань өглөөний цай уудамгүй, гэнэт өдөр их иддэг, усны хэрэглээ маш бага байгаа нь зүрх судасны өвчлөг, нойр булчирхайн үрэсэл, даралт ихсэх, цаашлаад сахрын өвчлөл үүсгэж болзошгүй байна. Анхан шатны үзлэг шинжилгээний дараа дараагийн шат руу үзүүлэх шаардлагатай малчдад хаана яаж хандан, үзүүлж оношлуулан эмчлүүлэх боломжтой талаар заавар чиглэл өглөө.

ХАРИЛЦАГЧ ФЕРМЕРҮҮДИЙН ТУРШЛАГА СУДЛАХ ХӨТӨЛБӨР

Бид харилцагч фермерүүддээ зориулан "Хөх хог - Шилийн гол" -ын туршлага судлах хөтөлбөр зохион байгуулж, 5 эмэгтэй 7 эрэгтэй, нийт 12 харилцагч хамрагдлаа. Хөтөлбөрийн хүрээнд фермерүүд маань орчин үеийн техник технологийн шийдлээр хүний хөдөлмөр хөнгөвчилсөн фермийн аж ахуйг хэрхэн бий болгох, малын өвчлөлөөс сэргийлэх, түгээмэл тохиолддог малын өвчлөлийг гэрийн нөхцөлд эмчилж, илээршуулах, фермийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, техник, тоног төхөөрөмжийн шийдлүүд нэвтрүүлэх, тэжээл бэлтгэл, үхрийн маллагааг яаж хийвэл илүү өндөр үр шимийг хүртэх гэх мэт олон төрлийн туршлагыг нүдээр үзэж, мэргэжилтнүүдээс судлахаас гадна өөрсдөд хэрэгцээтэй тоног төхөөрөмжийн худалдан авалтыг чанартай газраас хямд үнээр худалдан авах. Мөн Хөх хотод байрлах дэлхийд алдартай ИЛИ сүүний үйлдвэртэй танилцлаа. Малчид фермерүүдийн энэхүү хөтөлбөрт хамрагдсанаар Монгол Улсын фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэгт бид итгэлтэй байна.



ХАРИУЦЛАГАТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Бид үндэсний үйлдвэрлэлтэй байгальд ээлтэй, шударга хөдөлмөрт тулгуурлуулсан хөгжүүлэхийг зорин MONT-YAK брэндээрээ дамжуулан Архангай аймгийн Чулуут сумын малчидтай хамтран, хаягдал багатай, тогтвортой үйлдвэрлэл явуулах, орон нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлж байна. "Тэнгэр тэтгэж, байгаль урласан, тансаг идээ" хэмээх уриатай энэхүү брэнд нь байгаль, өв соёл, хариуцлагыг хослуулсан бүтээгдэхүүний жишиг юм.

ОРГАНИК, ИННОВАЦЛАГ, ӨВ СОЁЛ ШИНГЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

MONT-YAK брэндийн бүтээгдэхүүнүүдийг бид хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд нэвтрүүлж, уламжлалт Монгол цагаан идээний үнэ цэнийг сэргээн таниулах зорилготой. 2024 оны 10-р сард MONT-YAK брэндийн гурван төрлийн хайлмаг болон шар тос зэрэг нийт дөрвөн бүтээгдэхүүн нь Монгол Улсын Итгэмжлэгдсэн байгууллага **Эс Эф Си Эс (Swiss Food Certification Services)** байгууллагаас олгодог **органик хүнсний олон улсын гэрчилгээг авсан**. Энэхүү гэрчилгээ нь бүтээгдэхүүний боловсруулалт, үйлдвэрлэл, шошгололт, худалдаалах бүх шатанд органик шаардлагыг бүрэн хангаж байгааг баталгаажуулж байна.





Зорилго:

Эх дэлхий, байгаль орчинд үлдээх бүл үл мөрөө багасгахын тулд сэтгэлгээний хэвмэл хязгарыг дөвж, сэтгэл зүтгэл гарган, өвөг дээдсийнээ хадгалан үлдэсэн байгаль экологийн тэнцвэрийг идэвхтэй хамгаална.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ТООЦООЛОЛ БА БИДНИЙ ОРОЛЦОО

Тогтвортой хөгжлийн зорилгыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд олон талт оролцоо зайлшгүй шаардлагатай. Үүнд төрийн байгууллагууд, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллагууд, хөгжлийн түншүүд болон хувийн хэвшлийн идэвхтэй хамтын ажиллагаа чухал байр суурь эзэлдэг.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн 17 зорилгод хүрэх үүднээс 2030 он хүртэл хүлэмжийн хийн ялгарлаа 22.7 хувиар бууруулах үндэсний зорилт тодорхойлон ажиглаж байна.

АПУ ХК нь энэхүү зорилгод бодитой хувь нэмэр оруулах хариуцлагаа ухамсарлан, анх удаа групп компанийн хэмжээнд Хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) Хамрах хүрээ 1, 2, 3-ийн тооцооллыг олон улсын аргачлалд тулгуурлан хийлээ. Энэ нь бидэнд ялгарлаа бууруулах арга хэмжээг ирээдүйд шинжлэх ухааны үндэслэлтэй, үр дүнтэй төлөвлөх, хариуцлагатай тогтвортой үйл ажиллагаа эрхтэх чухал суурь алхам боллоо.

Нийт хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ

404,693.39 тн CO₂e

АПУ ХК-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүд нь борлуулалтын дараах нэмэлт боловсруулалт шаардахгүйгээр шууд эхсийн хэрэглэгчдэд хүргэгддэг бөгөөд францайз болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэгдэггүй тул Хамрах хүрээ 3-ын Ангилал 10, 14, 15-ыг хамруулаагүй болно.

УДГАЛГАЛ

АПУ ХК-ийн ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ҮНЭ ЦЭНИЙ

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ҮНЭ ЦЭНИЙ ГЭЛЭГДЭХ ХАНА

ХАВЧИЛТ

Хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ын тооцооллын аргачлал

АПУ ХК нь ХХЯ-ыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалд үндэслэн тооцооллоо. Үүнд

- ISO 14064-1:2018 (Part 1) стандарт
ISO 14064-1 стандарт нь байгууллагын хамжээнд хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тооцоолох, тайлагнах олон улсын стандарт юм. Энэхүү стандарт нь:
 - Ялгарлын тооцооллын хамрах хүрээг тодорхойлох,
 - Мэдээллийн чанар, нарийвчлал, ил тод байдлыг хангах
 - Удирдлагын тогтолцоо болон сайжруулах боломжийг тодорхойлох зорилготой.
- "GHG Protocol Corporate Value Chain (Scope 3) Accounting and Reporting Standard, Version 1.0" буюу "Хүлэмжийн хийн протокол Байгууллагын үнэ цэнийн сүлжээний (Хамрах хүрээ 3) ялгарлыг тооцох, тайлагнах стандарт, Хувилбар 1.0"

GHG Protocol-ын гарын авлагыг ашиглан бид нийлүүлэлтийн сүлжээн (Хамрах хүрээ 3) дэх ялгарлыг 15 ангилалд ангилж, тус бүрд тохирсон аргачлалын дагуу тооцоолол хийсэн. Энэхүү аргачлалын дагуу бид олон улсын жишигт нийцсэн, ил тод тооцооллыг гүйцэтгэж, гуравдагч байгууллагын баталгаажуулалт буюу **ISO 14064-1 сертификат авлаа.**

Хамрах хүрээ ба ангилал	Метрик тн CO ₂ e
Хамрах хүрээ 1: Шууд ялгарлууд	35,598.87
Хамрах хүрээ 2: Цахилгаан, дулааны хэрэглээнээс үүсэх шууд бус ялгарлууд	47,839.24
Биогеник ялгарлууд	1,167.35
Хамрах хүрээ 3 – Upstream	
Ангилал 1: Худалдан авсан бараа, үйлчилгээ	181,459.27
Ангилал 2: Үндсэн хөрөнгө	6,058.35
Ангилал 3: Шатахуун, эрчим хүчтэй холбоотой үйл ажиллагаа (Хамрах хүрээ 1, 2-д ороогүй)	19,346.39
Ангилал 4: Тээвэр, логистик	24,781.77
Ангилал 5: Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдал	12,160.19
Ангилал 6: Албан томилолт	339.63
Ангилал 7: Ажилчдын (гэр-ажлын хооронд тээвэр)	1,179.52
Ангилал 8: Түрээслсэн хөрөнгө	439.58
Хамрах хүрээ 3 – Downstream	
Ангилал 9: Тээвэр, логистик (after sale)	2.07
Ангилал 10: Борлуулсан бүтээгдэхүүний боловсруулалт	Хамаарахгүй
Ангилал 11: Борлуулсан бүтээгдэхүүн ашиглалт	71,085.48
Ангилал 12: Ашиглалтын дараах устгал	4,030.33
Ангилал 13: Түрээслүүлсэн хөрөнгө	372.72
Ангилал 14: Франчайз	Хамаарахгүй
Ангилал 15: Хөрөнгө оруулалт	Хамаарахгүй

УСНЫ МЕНЕЖМЕНТ

ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УС БОЛОВСРУУЛАХ БАЙГУУЛАМЖ БАРИХ ТӨСӨЛ

Үйлдвэрийн хаягдал ус боловсруулах үйлдвэр нь АПУ ХК-ийн төв үйлдвэр, АПУ Дэйри ХХК спиртийн үйлдвэр болон Баянзүрх дүүргийн Амгалан дахь М-Би-Си Азия Пасифик ХХК-ийн үйлдвэрээс гарч байгаа технологийн хаягдал усыг насос станцад цутгуулан, цугларсан хаягдал усыг цэвэрлэх үйлдвэр рүү 2 км шугам хоолойгоор дамжуулан хүргэж, "Дахин ашиглах цэвэрлэсэн ус, Техникийн ерөнхий шаардлага, MNS 6734-2018" стандартыг хангасан ус гаргаж авах зорилготой ажиллаж байна. Уг төслийн ажил 2023 оноос эхэлсэн бөгөөд төслийн ерөнхий концепц дизайны боловсруулах ажлын зөвлөх компаниар Австралийн BECA компанигай хамтран ажиллаж, төслийн барилга угсралт болон тоног төхөөрөмж нийлүүлэх, угсрах, суурилуулах, ОУ-ын тендерийн бичиг баримт боловсруулж, тендер зарлах ажлуудыг хамтран хийж гүйцэтгэлээ.

АПУ ХК Үйлдвэрийн хаягдал усаа боловсруулах байгууламжийг ашиглалтад оруулснаар дахин ашиглах цэвэрлүүлсэн ус гарган авч, өөрсдийн тээвэр түгээлтийн машин угаалга, үйлдвэрийн гадна талбайн цэвэрлэгээ зэрэг компанийн дотоод хэрэгцээг хангахаас гадна үйлдвэрийн ойролцоох ноос, ноолуурын үйлдвэр, машин угаалгын төв зэрэг бусад хэрэглэгчдэд түгээх замаар цэвэр усны нөөцийг хэмнэх бодитой ажил болох юм. Үүгээр эсэсхгүй УБ хотын шинээр ашиглалтад орох Төв цэвэрлэх байгууламжид ирэх үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэх ачааллыг багасгах, Туул голын бохирдлыг бууруулах зэрэг урт хугацааны ач холбогдолтой төсөл юм.

Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 425 тэрбум төгрөг бөгөөд үүнээс 2024 онд 103 тэрбум төгрөгийг дэд бүтцийн судалгаа, зураг төсөл, бэлтгэл ажлуудад зарцуулаад байна. Төсөл эхлэнээс хойш судалгаа, тендерийн үйл ажиллагаа, дэд бүтцийн ажлуудад нийт 3 тэрбум төгрөг зарцуулсан байна.




УСНЫ НӨӨЦИЙГ ХЭМНЭХ ИННОВАЦЛАГ ШИЙДЭЛ

Конденсацийн усыг дахин ашиглах систем

2024 онд АПУ компанийн спиртийн үйлдвэрийн нэрлэлийн процесст ашигладаг уурнаас ялгарэх **конденсацийн усыг дахин ашиглах** системийн шугамын угсралт, танк болон насос суурилуулалтын ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Уг систем нь PID тохируулгатай буюу давтамж хувиргач мотортой автомат хяналтын горимд шилжсэн бөгөөд шугамын даралтын хэлбэлзлээс хамааран моторын эргэлтийг автоматаар зохицуулдаг.

Үр өгөөж

- Спирт нэрэх технологи ажиллагаанд ашигладаг эвэлрүүлсэн цэвэр усны оронд конденсацийн усыг ашигладаг болсноор жилд 3,104 тн цэвэр усыг хэмнэх боломж бүрдсэн.



Хаягдал халуун усыг ахуйн хэрэгтэнд болон халаалтын эх үүсвэрт болгон ашиглав.

Нэрлэлийн явцад ялгардаг өндөр температуртай хаягдал ус (Литерийн ус) -ыг **шаар, гурилын зутан бэлтгэх хэсгийг халаах**, мөн **үйлдвэрийн хэрэгтээний халуун усны** эх үүсвэр болгон ашиглаж эхэллээ. Энэ нь эрчим хүчний хэрэгтээг бууруулах, хаягдал халуун усыг үр дүнтэй, оновчтой ашиглах шийдэл болов.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

"Дахин боловсруулгаа – Go Recycle" аяны стратегийн ивээн тэтгэгчээр ажиллаж эхэллээ

АПУ ХК нь хог хаягдлын менежментийг улс орны хэмжээнд сайжруулах, хөгжлийг хурдасгах, иргэдийн хандлага, дадалд зэрэг өөрчлөлт авчрах зорилгоор **"Өнгө нэмье" ТББ**-аас хэрэгжүүлж буй **"Дахин боловсруулгаа – Go Recycle"** олон нийтийн боловсролын хөтөлбөртэй урт хугацаанд хамтран ажиллахаар шийдвэрлэв.

2024 оноос эхлэн уг аяны **ерөнхий ивээн тэтгэгчээр** ажиллаж, хог хаягдлыг зөв ангилах, дахин боловсруулах соёлыг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулж байна. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулахаас гадна олон нийтэд чиглэсэн бодит үр нөлөө бүхий санаачилгыг дэмжиж, тогтвортой хөгжлийн зорилгуудыг биелүүлэхэд анхаарч байна.

Аяны зорилго: Төрийн байгууллага, хувийн компаниуд, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид импортлогчид болон хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаж, иргэд олон нийтэд хог хаягдлын талаар бодитой мэдлэг ойлголтыг өгөх, дахин боловсруулах үйлдвэрүүдийг цэвэр түүхий эдээр хангаж, эцсийн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд оршино.

Аяны зорилтууд:

- Хог хаягдлын талаар мэдлэг ойлголт өгөх
- Итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх
- Хог хаягдлыг ангилан ялгах үйлдлийг дадал зуршил болгох
- Ангилсан хаягдлыг ангиллын дагуу тээвэрлэх



Хамтын ажиллагааны эхний үе шат

2024 онд дараах үндсэн чиглэлээр хамтын ажиллагаагаа хэрэгжүүлээ. Үүнд:

- АПУ төв оффис болон үйлдвэрийн хог хаягдлын нөхцөл байдлын судалгаа. Үйлдвэрийн хог хаягдлын менежментийн одоогийн нөхцөл байдал, ажиллагсдын мэдлэг, хандлагыг үнэлэх зорилгоор нийт **хоёр үе шаттай нарийвчилсан үнэлгээ судалгаа** зохион байгууллаа. Судалгаанд төв үйлдвэр болон төвийн нэгжүүд хамрагдав.
- "Плэйтайм 2024" наадмын хог хаягдлын менежментэд дэмжлэг үзүүлэв. Байгальд ээлтэй, хариуцлагатай арга хэмжээний жишиг болгон хөгжүүлэх зорилгоор "Плэйтайм 2024" наадмын хүрээнд хог хаягдлын зохион байгуулалт, ангилалт, мэдээлэл зөвлөгөөгөөр хангаж, хамтран ажиллалаа.

Судалгааны дүгнэлт



Судалгааны үр дүнд хийгдэх ажлууд:

- Төв үйлдвэрийн хог хаягдлын цэгийн шинэчилсэн зураг төлөвлөлт гаргаж, ашиглалтыг тодорхойлох
- Ангилалтай хогийн савнаас хэрхэн зөөж болон ангиллын дагуу цуглуулах, дахин боловсруулах үйлдвэрт тээвэрлэх үйл ажиллагааг төлөвлөн гаргах
- Судалгаанд төв үйлдвэр болон оффис нийт 39 төрлийн хог хаягдалтай бөгөөд 2024 оны хувьд 66.7 хувийг дахин ашиглаж эсвэл дахин боловсруулдаг гэсэн дүгнэлт гарав. 2025 онд бүх ажилтнуудын онцлогт тохируулан сургалтыг төлөвлөж, хог хаягдлаа зохиистойгоор хаяж, дахин боловсруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

ШИЛ ТАТАН АВАЛТ



АПУ компани нь нийт 18 аймгийн 650-700 харилцагчдаас лонхоо эргүүтэн татаж байна.

Татан авч буй эргэлтийн лонх

Архис



Шар айраг



2020 оноос хойш татан авсан лонхны тоо хэмжээ

- 12,742 тн
- 647 ширхэг ачааны машинд ачихтай тэнцэх
- 26,028 тн
- 1301 ш ачааны машинд ачихтай тэнцэх

БАЙГАЛЬ ОРЧНЫ ОЛОН УЛСЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН АУДИТ ХИЙЛГЭЛЭЭ

2024 оны 2-р улиралд АПУ ХК нь олон улсын ISO 14001 : 2015 Байгаль орчны менежментийн тогтолцооны стандартын дагуу SGS байгууллагын хуваарьт баталгаажуулалтад хамрагдлаа.

Аудитын үр дүнд үл тохирол илрээгүй бөгөөд шар айраг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд энэхүү тогтолцоог амжилттай нэвтрүүлж хэрэгжүүлж буйг баталгаажуулав.

Энэхүү үнэлгээ нь АПУ ХК-ийн байгаль орчны удирдлагын тогтолцооны үр нөлөө, олон улсын шаардлагад нийцсэн бөгөөд тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцж буйг баталгасан юм.



НАРААР ЭРЧИМЖСЭН APULSE ZONE: PLAYTIME 2024

АПУУ ХК нь 100 жилийн ойн хүрээнд **Playtime Festival** 2024 амьд хөгжмийн наадмын албан ёсны стратегийн түншээр хамтран ажилласан билээ.


Playtime Festival нь орчин үеийн хөгжмийн урлаг, соёлоор дэмжүүлэн Монгол улсын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилготойгоор 22 дахь жилдээ "Тогтвортой ногоон наадам" агуулгын дор зохион байгуулагдсан бөгөөд бид 2008 оноос хойш тасралтгүй хамтран ажиллалаа.

АПУУ компани өөрсдийн **APULSE Zone**-ийг нарны эрчим хүчээр цэнэглэж, арга хэмжээний нийт цахилгаан хэрэгсэлийг 10 хувийг буюу 250.8 кВт эрчим хүчийг нарны системээр хангаж ажиллалаа (нийт хэрэгсэл 2430 кВт). Бид нарны системээ нэг удаагийн арга хэмжээн дээр хэрэглээд зогсохгүй, өдөрсөөр АПУУ ХК-ийн пивсны шил савны хосийн сэрэлтүүлэгт ашиглаж байна. Энэ ажлын үр дүнд суурьлж бусад байршлууд дээрээ нарны систем байршуулах, эрчим хүч хөнхсөж, хүтэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Мөн бид "Дахин боловсрууллага - Go Recycle" ажлы хүрээнд APULSE Zone-д үүсэн бүх хог хаягдлыг ангилан алгаж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн юм. Хаягдлыг дараах төрлөөр ангилсан:

- Лааз
- Хуванцар
- Яагаар уут
- Бусад хог хаягдал

Энэхүү санаачилга нь олон нийтийн арга хэмжээнд хог хаягдлыг хариуцлагатайгаар ангилан дахин боловсруулах соёлыг түсэх зорилготой байв.



APULSE ZONE ДАХЬ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД

- **Нараар эрчимжсэн цэнэглэх цэгүүд:** Playtime хөгжмийн наадамд оролцогчдаар гар утас, цахилгаан хэрэгсэлээ Нарны эрчим хүчээр цэнэглэх шанс олгож боломжийг олгов.
- АПУУ компанийн дахин ашигладаг логотип татан авалтын процесс болон түүнтэй холбоотой мэдээллийг **ECO Booth**-ээр танилцуулав.
- **Эко урлагт** ReParker компанитай хамтран аргачлан цаасаар номын хаягуудыг захидал хийх болон Эко Урлагын хамт олонтой лааз, хувицар савыг дахин ашиглан үзэж, цэцгийн сав бүтээж үйл ажиллагааг 4 хонгирын туршид байршуулсан.
- **Fireside Talk:** ТУЗ-ийн дарга П. Болсайхан, UB Comedfun үүсэн байгуулагч Б. Батбилэг нарын оролцогчтойгоор АПУУ ХК-ийн тогтвортой хөгжмийн бодлого, үйл ажиллагааг танилцуулав.
- **Өмөөний дасгал:** Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих дасгал.
- **Sound Meditation:** Дуу авчаны бясалталаар оюун санаагаа амрааж үйл ажиллагаа.
- **Big Sisters Comedy**
- Томоохон арга хэмжээнүүдэд сэргээгдэж эрчим хүч ашигладаг, хог хаягдлаа ангилж хариуцлагатайгаар дахин боловсруулдаг соёлыг нэвтрүүлж **APULSE Zone**-оо заслаа.



“ТУНГАЛАГ ТУУЛ” УЛАМЖЛАЛТ ХОГ ХАЯГДАЛ ЦЭВЭРЛЭХ БОЛОН МОД ТАРИХ ӨДӨРЛӨГҮҮД

АПУ ХК-ийн хамт олон жил бүр “Тунгалаг Туул” аяны хүрээнд голын ай савыг цэвэрлэх болон мод тарих өдөрлөгүүдийг зохион байгуулж хөвшээд байна. Аяны гол зорилго нь хог хаягдлыг бууруулах, үүнд хамт олны оролцоог бэхжүүлэхэд оршино.

Энэ жил Улаанбаатар хотын Дунд гол болон Туул голын эрэг, Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь Хараа голын эргээр 20 га орчим газрын хог хаягдлыг цэвэрлэхэд нийт 200 гаруй ажилтнууд маань хамрагдлаа.

Бид “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд жил бүр мод тарьдаг ба 2024 онд 1500 ширхэг хайлаас модыг “Инчон мөрөөдлийн төгөл”-д тарилаа. Энэ жилийн мод тарьсан байршлын онцлог нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 28 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үүсмэл хур жогийн цэг байсан газрыг 2018 оноос эхлэн Солонгос улсын Инчон дүүргийн нэрэмжит төгөл болжээ. 2027 он хүртэл ногоон орчин болгон бүрдүүлэхээр хоёр улсын хоорондын төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа газар юм.

Бид “Бахархалт Монгол”
тогтвортой хөгжлийн стратегийн
Ногоон, цэвэр тунгалаг баганын
хүрээнд ирээдүйн дэлхийгээ эрүүл
ногоон байлгахын төлөө зорилт
тавин ажилласаар байна.





Зорилго:

Хамт олон, бусад гол оролцогч талууд маань хөгжиж дэвших боломж бүхий Монгол гэр бүлийн үнэт зүйлд нийцүүлсэн ажлын орчныг хөгжүүлснээрээ манлайлагч ажил олгогч болно.

Бид тогтвортой хөгжлийн стратегийн салшгүй хэсэг болох хүний хөгжил, ажилтны сайн сайхны төлөөх үйл ажиллагаагаа өргөжүүлж, илүү хүртээмжтэй, эрх тэгш, хөгжлийг дэмжсэн байгууллагын соёлыг бэхжүүлсээр байна. Хамт олныхоо авьяас чадвар, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, хувь хүний өсөлт, нийгмийн оролцоог дэмжсэн олон талт хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлж байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ БА СУРЦ ХӨГЖИХ ОРЧИН

2023 онд үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь 28% байсан бол 2024 онд 20.1% болж буурав. Ажилтнуудын сургалт хөгжлийн цаг нэмэгдэн 2023 онд нэг ажилтанд дунджаар 5.53 цаг байсан бол 2024 онд 12.3 цаг болж өссөн үзүүлэлттэй байна.



Цалингийн харьцаа: 2024 онд эмэгтэй ажилтнуудын дундаж цалин эрэгтэй ажилтнуудаас 3.9 хувиар өндөр байгаа нь ажлын байрны төрөл, онцлогоос шалтгаалсан үзүүлэлт юм.

АЖИЛЛАСАН ЖИЛ:



ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН

- Нийт ажилтны 1.6%-ийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

АГУУ компанийн 296 ажлын байранд хүртээмжтэй байдлын үнэлгээ хийгдэж, тэр дотроос хурдан хугацаанд тохируулга хийх боломжтой 10 ажлын байрыг сонгон авч, тохируулгуудыг шат дараатай хийлгэв. Бэлэн болсон ажлын байрыг нээлттэй зарлах болон нийгмийн ажилтнуудад мэдээлэл түгээж, сонгон шалгаруулалтыг хийж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тэгш оролцоог дэмжих бодлогыг шат дараатайгаар хэрэгжүүлж байна. Үүнд:

- Албан баримт бичгүүдийг Брайл үсгээр бэлтгэж,
- Тэргэнцэрт тохиромжтой дэд бүтцийн шинэчлэл (машинны зогсоол, шатны төхөөрөмж)
- Хүний нөөцийн ажилтнуудыг дохионы хэлний сургалтад хамруулах зэрэг ажлуудыг хийв.

ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАХ ОРЧИН

АГУУ групп Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн (ХАБЭА) холбогдолтой 14 бодлого, журам, Heineken-ийн "Амь наснаа хамгаалах 12 амлалт"-ыг мөрдлөг болгон ажилладаг. 2024 онд үйлдвэрлэлийн осол бүртгэгдээгүй нь аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэнийг илтгэж байна.

2024 онд ХАБЭА чиглэлээр:

- **Аюулгүй ажиллагааны талаарх мэдээлэл түгээх аянууд**
- **Галын аюулаас урьдчилан сэргийлэх болон бэлэн байдлыг хангах үйл ажиллагаа**
- Нийт 4 байршилд гал унтраах иж бүрэн тоног төхөөрөмж болон галын тусгай хувцсаар тоноглогдсон цэгүүдийг байгуулсан.
- Нийслэлийн онцгой байдлын газартай хамтран галын аюулгүй байдлын сургалт болон дадлага сургуулийг амжилттай зохион байгууллаа.
- **Сэрээт өргөмчийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр**
- Нийт 5 агуулахад 2 багаар 30 байршилд дотоод аудит хийв.
- 4 агуулахын эрсдэлийн үнэлгээ хийв.
- Агуулахын 4 байршлын ажилтнуудад 60 хүнцэгийн сургалт оров.
- **"Аюулгүй жолоодлогын манлайлагч" аян**
- Нийт 120 автомашинд 4 байршил дээр Тээвэр Түгээмжийн Албаны ахлахуудтай хамтарсан үзлэг шалгалт хийв.
- GPS болон хар хайрцаг телематикийн хэрэгжлтийг 120 автомашинд хийв.
- Нийт 200 ажилтанд 10 удаагийн давхардсан тоогоор 325 хүнцэгийн сургалт орлоо.
- Эргономикийн сөрөг хүчин зүйлийг бууруулахад нурууны бүс болон Нэг Бүрийн Хамгаалах Хэрэгслийг сонгон хэрэглэх, жолоочийн ядралтыг хянах менежментийн төлөвлөгөөг боловсруулж ажиллалаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ НЭГЖ



9348

Эмчийн үзлэг



2540

Булчин, судас, дусал,
арьсан доорх тариа



8769

Бариа, бумба,
шарпага



1120

Хүнсний үйлдвэрийн
ажигчдын урьдчилан
сэргийлэх үзлэг

АЖИЛТНЫ САЙН САЙХАН БАЙДЛЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРҮҮД

- **NOVA Employee Loyalty:** Бид хүн төвт бодлого, хүчирхэгжсэн хамт олон баганын хүрээнд ажилтан бүрийн нийгмийн хэрэгцээ, тогтмол урамшуулал, сургалт хөгжил, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ гэх мэт цогц хүний нөөцийн урамшуулал хөнгөлөлтийн үйл ажиллагааг багтаасан **нэгдсэн цахим платформ** бүхий хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. NOVA нь ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг ажилтнуудын маань хамгийн дуртай хөтөлбөрүүдийн нэг юм.

APU компани ур чадварт суурилсан хамт олон байх алхмуудыг шат дараалан хийж, хүний нөөцийн инновацилаг орчин үеийн дижитал хөтөлбөрүүдийг ийнхүү санаачлан ажилласаар байна.



nova Employee Loyalty

- **BOOSTIBE:** Нийт ажилтанд зориулсан хөнгөлөлт, урамшуулал бөгөөд ажилтан компанид хэдий хугацаанд ажилласнаас шалтгаалан хөнгөлөлт, урамшуулал авах үйлчилгээний эрх, үнийн дүн нэмэгддэг систем юм. Эрүүл мэнд (эрүүл мэндийн үзлэг, даатгал, сувилал г.м) болон бүтээгдэхүүн (хүнс, бензин, шатахун, спорт, фитнес, энтертайнмент, цахим худалдаа г.м) сонгох боломжтой юм.



APU Lead

- **Удирдлагын Манлайллын Ур Чадварыг Хөгжүүлэх Хөтөлбөр:** APU компанийн удирдах түвшний ажилтнууд бизнесийн орчны өөрчлөлтийг мэдэрч, алсын хараатайгаар байгууллагыг манлайлан чөлүүлэх, инновацийг дэмжих, ирээдүйн манлайлагчдыг төлөвшүүлэн хөгжүүлэх зорилготой. Энэ хүрээнд компанийн удирдах ажилтны хөгжлийн хөтөлбөрийн судалгаа, хөгжүүлэлтийг олон улсын туршлагатай зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтран амжилттай хэрэгжүүлжээ.

УДГАЛГАЛ

АПУ ХҮНИЙ ТӨТӨВРӨЙЛХӨН ӨНӨН СЭРГЭЛТ

ТОГТООЛГОН АЖИЛ МЭНДЭЙН ГЭМЭ

ХАВЧИЛТ

• АПУ Академи

2024 онд 16 багшийн бүрэлдэхүүнтэй ажиллав.



198 цаг

танхимын сургалт



1221 ажилтан

сургалтад хамрагдсан



96 цаг

сургалч багш бэлтгэх хөтөлбөр

• Көучинг хөтөлбөр

Нийт 77 удаагийн көучинг уулзалт хийгдсэн



77

көучинг уулзалт



• Орон сууцны дэмжлэг

Орон сууцны урьдчилгаанд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд компанидаа үнэ цэнийг бүтээж, идэвх санаачилгатай ажилласан нийт 50 ажилтанд байрны урьдчилгааны дэмжлэг үзүүлжээ.



• Хобби клубууд

Бид 2015 оноос хойш ажилтнуудынхаа сонирхол, хоббиг дэмжиж, чөлөөт цагийг эвч боловсон өнгөрүүлж, хамт олны хоорондын уялдаа холбоог сайжруулах үүднээс "Сонирхлын клуб"-үүдийг байгуулан тогтмол үйл ажиллагааг явуулж байна.



СОЁЛ, ХАМТЫН ҮНЭ ЦЭН

“Хамаг Монгол - Дэлхийд” соёлын фестивалыг

100 жилийн ойдоо зориулан брэнд бүтээгдэхүүнээ экспортологч болон хамтын ажиллагаатай улсуудын соёлыг түгээхийн зэрэгцээ Монгол өө соёлоо түгээх зорилготой “Хамаг Монгол - Дэлхийд” уламжлалт соёлын фестивалийг нийт хамт олноороо дунд зохион байгуулж, шилдгүүдээ шалгаруулан өргөмжиллөө.

Хамтын нөхөрлөл, нэгдлийг бий болгох, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх зорилготой “Хамаг Монгол” урлагийн наадамд нийт найман багийн 2400 гаруй ажиллагсад, залуус авхаас чадвар, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, түүнчлэн тухайн улсын хоол хүнс, ахуйн соёлыг харуулсан үзэсгэлэн дэлгэсэн цогц арга хэмжээ болж өндөрлөлөө.



Бидний бахархал

Монголын сонсголын бэрхшээлтэй иргэдийн сагсан бөмбөгийн холбооны тамирчин, АГУ компанийн агуулахын ажилтан Т.Дэлгэрмөнх нь 2024 оны 9-р сард Австрали улсын Мельбурн хотод Олон Улсын Сонсголын Бэрхшээлтэй Иргэдийн Сагсан Бөмбөгийн Холбооны Ази-Номхон Далайн бүсийн нээлттэй тэмцээнд оролцож 3-р байр эзэлснээр Япон улсад Сонсголын бэрхшээлтэй иргэдийн Олимпын наадамд эх орноо төлөөлөн оролцов. Энэхүү амжилт нь сонсголын тусгай хэрэгцээтэй иргэдийн спортод оруулах хувь нэмэр, нийгэмд хэрэг өөрчлөлт авчрах манлайллыг харуулсан төдийгүй АГУ ХК-ийн хүний эрх, олон талт байдлыг хүндэтгэн дэмжих бодлогын бодит илэрхийлэл юм.



“INNOV-TALENT” ИННОВАЦЛАГ УР ЧАДВАРЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

2024 оны төгсгөлд бид “INNOV-TALENT” инновацлаг ур чадварын тэтгэлэгт хөтөлбөрийг оюутнуудын дунд заргалаа. Уг хөтөлбөрт шалгарсан 100 оюутан:

- Хувь хүний болон мэргэжлийн ур чадваруудыг нэмэгдүүлэх АГУ Академийн сургалтууд нэгдсэн хөтөлбөр, хувь хүний хөгжлийн сургалтын багцад (LMS NOVA) хамрагдах
- Цалинтай мэргэжлийн дадлага
- 2 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэг
- Инновацлаг төсөл хэрэгжүүлэх
- Нийгэмд чиглэсэн сайн дурын ажил гэх мэт олон төрлийн хөтөлбөрт хамрагдах, өөрийгөө хөгжүүлэх боломжтойгоороо онцлог юм.





Зорилго:

Өдөр тутмын амьдрал болон хэрэглээнд эрүүл сонголтлуудыг сэдэлжүүлж, боломжийг нэмснээр Монгол мөн чанар шингэсэн зохистой амьдралын хэв маягийг дэвхээснэ.

ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ НЬ

АПУ ХК нь бүтээгдэхүүнээ зөв, хариуцлагатай хэрэглээтэй уялдуулан түгээхийг эрхэм зорилгоо болж ирсэн билээ. 2024 онд "Гайхамшигт жолооч" нөлөөллийн аян болон 21+ насны хэрэглэгчдэд зориулсан контент түгээх зэрэг олон нийтийн боловсрол, хандлагын өөрчлөлтөд чиглэсэн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

- "Гайхамшигт жолооч" нөлөөллийн аяныг амжилттай зохион байгуулж, хариуцлагатай хэрэглээг уриалсан.
- Зөвхөн 21+ насны хэрэглэгчдэд зориулсан контент, сурталчилгааг түгээж, хуулийн хэрэгжилт, ёс зүйг ханган ажилласан.
- Хэрэглэгчдэдээ сонголт өгөх зорилгоор 0.0% согтууруулах агууламжтай шар айргийг шинээр үйлдвэрлэх судалгааг хийж байна.

Зөв зохистой хэрэглээг дэмжих зорилгоор согтууруулах ундааны спиртийн агууламжийг шат дараалан бууруулж, хатуулаг багатай шинэ төрлийн коктейль (Ready To Drink) зэргийг үйлдвэрлэж байна.



ЭРҮҮЛ МЭНДЭД ЭЭЛТЭЙ БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

- Мөн эрүүл мэндийг дэмжсэн, байгалийн гаралтай бүтээгдэхүүний цувралуудыг өргөжүүлэв.



Спортлоор дамжуулан нийгмийн эрүүл мэндийн хөгжилд хувь нэмэр оруулж байна.

Спорт бол зөв нэгдэл, сахилга бат, эрүүл мэндийн бэлгэ тэмдэг бөгөөд ирээдүй хойч үеийг эрүүл, зөв амьдралын хэв маягт уриалан дууддаг хүмтэй хэрэгсэл юм. АПУ ХК нь спортод үзүүлж буй дэмжлэгээрээ дамжуулан нийгмийн эрүүл мэндийг дэмжих, залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Бид спортод хайртай хэрэглэгч, харилцагчдадаа зориулан онцгой бүтээгдэхүүн, урамшуулал, спортын арга хэмжээг дэмжих олон талт бодлого хэрэгжүүлдэг. Үүний хүрээнд олон улсын болон үндэсний спортын үйл ажиллагааг дэмжих, шууд дамжуулалтаар хүргэх, спортын тэмцээн, уралдааныг ивээн тэтгэх, үндэсний спортын төрөлд оролцогчдоо дэмжих зэргээр нийгэмд чиглэсэн идэвхтэй оролцоотой ажиллаж байна.

Цаашид ч спортын үнэ цэнийг олон нийтэд түгээх, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих, нийгмийн эрүүл мэндийг сайжруулах үйлсэд хувь нэмрээ оруулахыг зорин ажилласаар байх болно.





**ГАЙХАМШИГТ
ЖОЛООЧ**
уусан бол жолоо барьдаггүй

Powered by
**Согномд
Огноо**

APU COMPANY
Atokhin Plaza, Ulaanbaatar

Би хайртай бүхнийхээ төлөө

**ГАЙХАМШИГТ
ЖОЛООЧ БАЙХАА
АМЛАЖ БАЙНА.**

#уусан_бол_жолоо_барьдаггүй



Зорилго:

Монголын нээлттэй хувьцаат компаниудын дунд байгаль орчин, нийгэм, засаглалын нөлөөлөөрөө жишээ байгууллага байна.

ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ

АПУ ХК нь ханган нийлүүлэгчидтэйгээ урт хугацааны харилцан ашигтай, хариуцлагатай харилцааг эрхэмлэн ажилладаг. 2024 онд бид ханган нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдлыг нэмэгдүүлэх, ёс зүй дагах мөрдөх зарчим, хүний эрхийн стандартуудыг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандууллаа. Мөн хариуцлагатай худалдан авалтын удирдамжуудыг шинэчилж, бизнесийн эс зүйн дүрэм болон нийлүүлэлтийн эрсдэлийн үнэлгээг хамарсан ажлуудыг зохион байгууллаа.

Бид олон улсын UN Global Compact, Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDGs) зэрэг хөлөнбөрүүдтэй уялдуулан, Дэлхийн Тайлагналын Санаачилга (Global Reporting Initiative) байгууллагын нийгэм, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг ил тод, хариуцлагатай тайлагнах олон улсын стандартын дагуу тайлагнахыг зорьж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

АПУ ХК нь байгаль орчин, нийгэм, эдийн засагт ээлтэй, ил тод, хариуцлагатай засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлж байна. Бид аливаа эрсдэлийг богино болон урт хугацаанд зөв тодорхойлж, үнэлэн, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тогтвортой хөгжилт суурилсан эрсдэлийн удирдлагын соёлыг төлөвшүүлэхэд онцгой анхаарч байна. Ингэснээр бид тодорхойгүй нөхцөл байдлад дасан зохицож, шинэ боломжийг нээх замаар тогтвортой үнэ цэнэ бүтээх зорилготой.

2023 онд бид анх удаа E1 нэгдлийн үзэгдлийг эрсдэлийн үнэлгээнд тусган ажилласан нь уур амьсгалын эрсдэлийг системтэй авч үзэх эхлэл болсон. Энэхүү үйл ашгийн хүрээнд хур тунадас, гад, хэт халалт, хүйтрэлт, усны нөөц, тээвэр, логистикийн доголдол зэрэг биет эрсдэлийн тодорхой асуудлуудыг анхаарлын төвд оруулсан.

Бидний зүгээс уур амьсгалын эрсдэлийг илүү гүнзгийрүүлэн авч үзэх шаардлага зүй ёсоор бий гэж үзэж байна. Байгаль цаг уурын өөрчлөлтийн урт хугацааны нөлөө болон түүнийг дагасан шилжилтийн эрсдэлүүд тухайлбал:

- Хүлэмжийн хийг бууруулахтай холбоотой бодлого, хууль зохицуулалтын өөрчлөлт,
- Зах зээлийн шаардлагын өсөлт,
- Ногоон санхүүжилтийн болзол, хөрөнгө оруулалтын урсгалын өөрчлөлт зэрэг нь манай салбарт бизнесийн загвар, бүтээгдэхүүний бүтэц, үйлдвэрлэлийн процесс шүүд бадам нөлөөлөх өндөр магадлалтайг бид хүлээн зөвшөөрч байна.

Тиймээс 2025 оноос эхлэн бид уур амьсгалын эрсдэлийн талаар шат дараатай илүү нарийвчилсан үнэлгээ, мэдээлэлд суурилсан удирдлагын хандлагыг боловсруулж, олон улсын санхүүгийн тайлагналын стандартын зөвлөлийн (IFRS ISSB) тогтвортой байдлын шинэ стандартуудын (S1 General Requirements for Disclosure of Sustainability-related Financial Information, S2 Climate-related Disclosures) дагуу тайлагнах зорилгыг шат дараатай тавин ажиллах юм.

- S1 нь байгууллагын тогтвортой хөгжлийн бүхий л хүчин зүйлс бизнесийн үнэ цэнэ, хөрөнгө оруулагчид болон бусад гол оролцогч талуудад хэрхэн нөлөөлж буй талаарх нэгдсэн, иж бүрэн мэдээллийг тайлагнах ерөнхий стандарт.
- S2 нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, боломжийн талаар нарийвчилсан мэдээлэл тайлагнах стандарт.

Онцолж буй үндсэн эрсдэлүүд

Байгаль цаг уурын өөрчлөлт, уур амьсгалын биет болон шилжилтийн эрсдэлүүд

- Хүлэмжийн хийн ялгарлын зохицуулалт ба шаардлага
 - Геополитикийн зөрчилдөөн, эдийн засгийн тодорхойгүй байдал
 - Шинээр боловсруулагдаж буй "уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тухай" хууль, холбогдох бодлогын шаардлагауд
 - Мэдээллийн урсгал, технологийн доголдол
- Эдгээр эрсдэлүүд нь харилцан уялдаа холбоотой тул цогцоор нь хянах, удирдах шаардлагатай. Жишээлбэл, зарим бүс нутагт хур тунадасны эрс нэмэгдэлт, цэр, эсвэл эсрэгээр ган зуд нь түүхий эдийн нийлүүлэлт, тээвэр логистик, ус ашиглалт, эрчим хүчний зардал зэрэгт сөрөг нөлөө үзүүлж байна.
- Бидний авч буй хариу арга хэмжээний жишээнүүд:
- CO₂ ялгарлыг бууруулах уурын зуухны шинэчлэл
 - Саарал усыг дахин ашиглах систем
 - Хог хаягдлын стратеги
 - Валютын форвард, своп хэлцэл
 - Түүхий эдийн нийлүүлэлтийн эрсдэлийг бууруулах нөхөн нөөц бүрдүүлэлт

ГАДААД ОРЧНЫ ЭРСДЭЛ

2024

ЭРСДЭЛҮҮД		БОЛОМЖУУД	
1	Геополитикийн тодорхойгүй байдал, аливаа өмчийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	1	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
2	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	2	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
3	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	3	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
4	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	4	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
5	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	5	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
6	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	6	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
7	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	7	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
8	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	8	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
9	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	9	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
10	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	10	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
11	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	11	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
12	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	12	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
13	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	13	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
14	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	14	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
15	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	15	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
16	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	16	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
17	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	17	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
18	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	18	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
19	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	19	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
20	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	20	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
21	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	21	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
22	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	22	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
23	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	23	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
24	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	24	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
25	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	25	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
26	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	26	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
27	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	27	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
28	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	28	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
29	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	29	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
30	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	30	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
31	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	31	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
32	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	32	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
33	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	33	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
34	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	34	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
35	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	35	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
36	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	36	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
37	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	37	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
38	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	38	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
39	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	39	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
40	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	40	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
41	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	41	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
42	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	42	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
43	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	43	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
44	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	44	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
45	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	45	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
46	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	46	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
47	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	47	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
48	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	48	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
49	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	49	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2
50	Хүлэмж, агаарын богино мөргөлийн хөрөнгийн хөгжилтэй бодлогоуд	50	Эдийн засгийн өсөлт, мөхөх эхлэлээр эхлэлт S2

ТОС ХОЛБООНЫ ДЭМЖИГЧ ГИШҮҮН

АПУ ХХ нь 2022 оноос хойш бизнесийн тогтвортой байдлыг эрхэмлэдэг Тос (Тогтвортой санхүүжилтийн холбоо)-ны дэмжигч гишүүнээр ажиллаж байна. Уг холбооны гишүүнчлэлийн цар хүрээ жилээс жилд тэлж, 2024 оны байдлаар банк, банк бус санхүүгийн байгууллага, бизнес, даатгал, сургалт, судалгааны байгууллагуудыг хамарсан 43 байгууллага нэгдэн ороод байна. Бид уг холбооны гишүүнчлэлээр дамжуулан тогтвортой хөгжилд суурилсан бизнесийн засаглал, ил тод байдал, хариуцлагын зарчмуудыг салбар хооронд сурталчлахад хувь нэмрээ оруулахыг зорьж байна.



ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ

АПУ ХХ нь тогтвортой хөгжил, ногоон шилжилтийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд олон улсын сайн туршлагыг судлах, хамтран ажиллахыг чухалчилдаг. Энэ хүрээнд 2024 оны 9-р сарын 14-23-ны өдрүүдэд Исланд, Швед улсад эхлэн байгуулагдсан "Өндөр түвшний туршлага судлах аян"-д Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Эрчим хүчний үндэсний төв, арилжааны банкууд болон хувийн хэвшлийн төлөөлөл оролцсон энэхүү аялал нь тогтвортой хөгжил, ногоон санхүүжилт, сэргээгдэх эрчим хүч зэрэг салбарт Нордикийн орнуудын туршлага, шийдлийг судлах, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх зорилготой байсан юм.

Тус оролцоо нь олон улсын хамтын ажиллагааг дэмжих, цаашид тогтвортой бизнесийн шилжилтийг ахиулах чиглэлд компанийн бодлогыг уялдуулахад дэмтэй алхам болж өнгөрлөө.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

АПУ ХХ нь UNICEF-ийн Дэлхийн Хүүхдийн Өдөрт зориулсан "Blue Day" хамдивын гала арга хэмжээнд "Silver Sponsor" хэлбэрээр оролцож, хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр олон улсын санхүүжилт дэмжилээ.

НҮБ-ЫН СУУРИН ЗОХИЦУУЛАГЧИЙН АЙЛЧЛАЛ

2024 оны туршид бид олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэн, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж буйгаа харуулсан олон чухал уулзалтыг зохион байгууллаа. Тухайлбал, НҮБ-ын Суурин Зохицуулагч Талан Мишра-г "Монгол Баслаг" болон "Шигүдэри урлах үйлдвэр"-тээ хүндэтгэлтэйгээр хүлээн авч, инновац шингэсэн сүүний үйлдвэрлэлтэйгээ танилцуулсан юм. Орон нутгийн хөгжлийг дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангах, сүүний салбарт олон улсын стандарт, технологи нэвтрүүлэх чиглэлээр хийж буй манай үйл ажиллагааг ноён Мишра өндөрөөр үнэлж, цаашид бүх талаар дэмжин ажиллахаа илэрхийлсэн билээ.



COP29: ХАРИУЦЛАГАТАЙ ХУВИЙН ХЭВШИЛ

Бид нийгэм, байгаль орчны өмнө хүлээн зоригтой үүрэг ухамсарлан, дотоод болон олон улсын түвшинд тогтвортой хөгжлийг ургашуулах түншлэл, хамтын ажиллагааг идэвхтэй эрэлхийлж байна. Энэ зорилгын хүрээнд манай тогтвортой хөгжлийн баг 2024 онд болсон НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн таларх 29 дэх удаагийн бага хуралд (COP29) Монгол Улсын хувийн хэвшлийн төлөөлөөр оролцлоо.

Энэхүү чухал олон улсын арга хэмжээнд оролцсон оор:

- Дэлхий дахины тогтвортой хөгжлийн шинэ хандлага, туршлагыг судалж, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг шийдлүүдтэй танилцсан;
- Бизнесийн салбарт тогтвортой байдлыг нэвтрүүлэх олон улсын чиг хандлага, хөрөнгө оруулагчдын хүлээлт, стандартын талаар ойлголтгоо тэлсэн;
- Цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор гадаад, дотоодын байгууллагуудтай шинэ түншлэлүүдийн суурь болсон.

Бидний зүгээс COP29-д оролцсон нь тогтвортой хөгжлийн стратеги болон зорилтуудыг дэлхийн жишигт нийцүүлэх чухал алхам боллоо.



КОМПЛАЕНСЫН НЭГЖ

Комплаенсын нэгжийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс 2023 оны 12 сарын 05-ны өдөр баталсан "Комплаенсын хяналтын заавар", 2023 оны 02 сарын 13-ны өдөр баталсан "Бизнесийн ёс зүйн дүрэм" багц бодлогын "Мөнгө угаахтай тэмцэх, хориг арга хэмжээний бодлого" болон 2024 оны 11 сарын 29-ний өдөр шинээр баталсан "Хориг арга хэмжээний журам"-ыг тус тус баримтлан ажиллав.

Хориг арга хэмжээг сэргийлэх

Бид аливаа худал, хууль бус үйлдлийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэхгүй байх зарчмыг баримталдаг бөгөөд 2023 оноос эхлэн Олон улсын LexisNexis системийн тусламжтай Компанитай гэрээлэгч хуулийн этгээд, хувь хүнийг шүүн шалгаж, хориг арга хэмжээнд орсон талтай аливаа бизнесийн холбоо тогтоохоос сэргийлэн ажилладаг.



Шүтэл үлээх

2024 онд бизнесийн ёс зүйн зөрчил болон аливаа зүй бус үйлдлийн талаар мэдээллийг хүлээн авах, нэрээ нууцалж мэдээлэл гаргах, гаргасан мэдээллийнхээ шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой "Шүтэл үлээх систем"-ийг ашиглалтад орууллаа. Уг системээр ирсэн мэдээллийг Комплаенсын нэгж хүлээн авч, ёс зүйн хороонд шилжүүлэн шийдвэрлүүлж, ТУЗ-д тайлагнадаг. 2024 онд системээр 5 мэдээлэл хүлээн авч, 100% шийдвэрлэсэн байна.




БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ

АГУУ компанид ТУЗ-өөс 2023 оны 02 сарын 13-ны өдөр батлагдсан "Бизнесийн ёс зүйн дүрэм" багц бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд АГУУ ХК болон түүний охин компаниудын бүхий л ажилтнууд үйл ажиллагаандаа ёс зүйн бодлого, дүрмийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Хүнчлэрийн бодлого	Өрсөлдөөний бодлого	Авлигээс урьдчилан сэргийлэх бодлого	Бэлэг, хандивын бодлого	Мөнгө угаахтай тэмцэх, хориг арга хэмжээний бодлого	Ашиг сонирхлын зөрчлийн бодлого	Компанийн хөрөнгө ашиглах бодлого
Заллиангийн эрэг бодлого	Нүүд мэдээллийн бодлого	Оюуны өмчийн бодлого	Олон нийтийн сүлжээ ашиглах бодлого	Согтууруулах ундааны хариуцажтай хэрэглээний бодлого	Нийгүүлэгчийн дүрэм	Сайтын арга хэмжээний бодлого

Үргэлж "Ёс зүй" Өөдөө

Бид баримталдаг зарчмаа эрсэмлэж, ёс зүйн бодлого, дүрмийн сургалтыг ажилтан бүрд явуулдаг ба 2024 онд MS 365 - Learning Management System [LMS], Nova LMS цахим сургалтын платформоор дамжуулан нийт 369 ажилтанд орсон байна.



Шүтэл үлээх сувгууд:

Цахимгаар:

- Web site: www.speakup.apu.mn
- E-mail: speakup@apu.mn

Биечлэн:

- Шууд удирдлагадаа мэдэгдэх;
- Зохиргаа, хүний нөөцийн газар, Хуулийн алба, Үйл явц хяналт сайжруулалтын албаны ажилтнуудад мэдэгдэх;
- Байршил бүр дээр сонгогдсон Итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөр дамжуулан мэдээлэл гаргах боломжтой.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-ийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд компанийн засаглалын бодлого, дүрэм журам, зааврыг үе шаттайгаар шинээр болон шинэчлэн батлахаар төлөвлөснөөс 2024 онд дараах баримт бичгийг боловсруулж, ТУЗ-өөс баталсан байна. Үүнд:

Д/д	Баримт бичгийн нэр	Хэрэгжилт	Баталсан огноо, тайлбар
1	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам	Шинэчлэн баталсан	ТУЗ-ийн 2024 оны 02 сарын 16-ны өдрийн 24/03 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж, хөндлөнгүйн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байх заалтыг нэмсэн.
2	Тогтвортой хөгжлийн стратеги	Шинээр баталсан	ТУЗ-ийн 2024 оны 07 сарын 23-ны өдрийн 24/13 тоот тогтоолоор АГУ Групп компанийн 2030 он хүртэл баримтлах тогтвортой хөгжлийн стратегийг баталсан (дэлгэрэнгүйг тогтвортой хөгжил хэсгээс үзнэ үү).
3	Хориг арга хэмжээний журам	Шинээр баталсан	ТУЗ-ийн 2024 оны 11 сарын 29-ний өдрийн 24/22 тоот тогтоолоор батлагдсан энэхүү журмаар АГУ Групп компанийн үйл ажиллагаанд хориг арга хэмжээтэй холбогдуулан дагаж мөрдөх журмыг тогтоох, хоригийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, шалгалт хийх, хяналт тавих, сургалт зохион байгуулах, тайлан гаргахтай холбоотой харилцааг зохицуулна.
4	Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам	Шинээр батлах	Боловсруулж дууссан, ТУЗ-өөр батлуулахаар хүлээгдэж байна.

КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2022.06.09-ний өдрийн А/58 тушаалаар баталсан аргачлалын дагуу АГУ ХК-аас Кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг 2024 оны эцэст нэг удаа хийсэн ба СЗХ-ны Компанийн засаглал, комплаенсын хэлтсээс хянан баталгаажуулсан үр дүнг дор үзүүлэв.

АГУ ХК-ИЙН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХЯНАН БАТАЛГААЖИЛТ

		2024 оны I хагас жил			2024 оны эцэс	
Д/д	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	7	58%	10	83%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цагын урамшуулал	6	5	83%	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%
8	Компанийн соёл	6	5	83%	5	83%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%	9	90%
Нэгдсэн дүн		72	64	89%	68	94.4%
Үнэлгээний тайлбар		2. Дунд засаглалтай			1. Засаглал хэвийн буюу эрсдэлгүй	
Эрэмбэ		17-р байр			4-р байр	

АГУ ХК кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудаас 2024 оны жилийн эцсийн байдлаар 94.4%-ын үнэлгээгээр дөрөвдүгээр байранд эрэмбэлэгдлээ.



04

ХАВСРАЛТ

Монголын Хөрөнгийн Биржийн БоНЗ-ын үйл ажиллагааны тайлан

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

"Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам"-ын

Хавсралт 1.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Огноо (он, сар, өдөр):	2025 оны 4-р сарын 23
Үнэт цаас гаргагчийн нэр:	АПУ ХХ
Үнэт цаасны нэр, код (МХБ символ):	APU, 90
Салбарын ангилал:	Шингэн хүнс
Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон тогтой болон окин компаниудын мэдээлэл):	АПУ ХХ, М.Би-Си Азия Пасифик ХХК, Спирт Бал Бурам ХХК, СББ Трейд ХХК, АПУ Дэйри ХХК, АПУ Трейдиг ХХК
Тайлангийн хамрах хугацаа:	2024/01/01 - 2024/12/31
Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих и-мэйл хаяг, утас:	Э.Минхтуул Тогтвортой байдлын менежер minhkhtuul.e@apu.mn, 99087876
Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):	Ц.Эрдэнэбилэг Гүйцэтгэх захирал
Гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн даргын гарын үсэг:	



	Бүлэг	Шалгуур үзүүлэлт	Үзүүлэлт (2023)	Үзүүлэлт (2024)	Хэмжээг нэгж	Нэмэлт мэдээлэл	Холбоос
		Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд					
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	-	Тийм	АПУ ХХ нь "Дэлхийд танигдах эрхэм Монгол хүний оюун чадвар, ур ухаан, шинэчлэл, тогтвортой хөгжлийн ундарга байх" гэсэн алсын харагааа хэрэгжүүлэх хүрээнд Тогтвортой хөгжлийн стратеги батлан, байгууллагын бодлого, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмуудыг нөвтрүүлэн ажиллаж байна.	GRI 102
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Үгүй	Тийм	ТУЗ-ийн 2024.07.23-ны өдрийн журлаар "Бахархалт Монгол" тогтвортой хөгжлийн 2030 стратегийг батлан, хэрэгжлтийг хангаж ажиллаж байна. Дэлгэрэнгүй: Тогтвортой хөгжлийн 2024 оны жилийн тайлангаас уншина уу.	GRI 103, ISO 14001
MS2.2			Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Үгүй	Үгүй	Тогтвортой хөгжлийн албан ёсны хороо байхгүй эсхий ч "Бахархалт Монгол" тогтвортой хөгжлийн 2030 стратегийн 5 баганын хүрээнд төлөвлөгдсөн ажлуудыг хариуцах С түвшний захирлууд томилогдон ажиллаж байна. Дэлгэрэнгүй: Тогтвортой хөгжлийн 2024 оны жилийн тайлангаас уншина уу.	GRI 103, ISO 14001
MS3.1			ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Үгүй	Үгүй	ТУЗ-ийн түвшинд тусгайлан томилогдсон гишүүн байхгүй боловч улирал бүр ТУЗ-д тайлагнадаг.	GRI 102
MS3.2		Бүтэц удирдлага	Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	Тийм	Гүйцэтгэх захирал	GRI 102
MS3.3			Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	Тийм	Тогтвортой байдлын менежер болон Тогтвортой байдлын ажилтан бүтэн цагаар ажилладаг.	GRI 102
MS3.4			Танай компани ТУЗ-ийн хурлын төлөөлөр тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?	-	Тийм	ТУЗ-д улирал бүр тогтмол тайлагнадаг.	GRI 102
MS3.5		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөлөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эсрэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Тийм	Тийм	ТУЗ-р батлагдсан эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны журам Групп компанийн хэмжээнд хэрэгждэг бөгөөд журамд тусгагдсан эрсдэлийн үнэлгээний өрөөний матрицаг ашиглан бүх төрлийн эрсдэл, боломж, түүн дотроо эдийн засаг, байгаль орчин, нийгмийн орноос ирэх эрсдэл болон боломжуудыг үнэлж ажилладаг.	SA88
MS4.1		Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	-	- цаг	Тогтвортой хөгжлийн тухай сургалт нь Шинэ ажилтнуудын сургалтын агуулгад орсон байдаг бөгөөд 2024 онд нийтдээ 12 удаа зохион байгуулагдсан. Нэг удаагийн сургалт нь аклын 8 цаг үргэлжлэх ба өнгөрсөн онд 162 шинэ ажилтан хамрагдсан байна.	GRI 102

MS4.2	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Тийм	Тийм		Дотоод аудитын нэгжийн удирдлагыг ТУЗ-нээс томилсон бөгөөд тус албан тушаалтан нь ТУЗ-ийн даргаар Аудитын хороонд шууд тайлагнан ажилладаг. Дотоод аудиторын ажлын чиглэлд үйл ажиллагааны аудит багтдаг бөгөөд компанийн хэмжээнд хэрэгжигч буй бүх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр ашгийг үнэлдэг. Мөн гүйцэтгэлийн аудитаар байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор удирдлагын тогтоосон хэмжүүрийг хангаж байгаа эсхийг үнэлдэг тул компанийн үрт хугацааны зорилготой уялдсан бүхий л үйл ажиллагааны хэрэгжилтийг шалгах нь аудитын чиг үүрэгт хамаардаг.	GRI 102, SDG 12
MS4.3			Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?	Тийм	Тийм		2022 оноос эхлэн Тогтвортой хөгжлийн жилийн тайлан гаргаж, олон нийтэд нээлттэй тайлагнаж байна. https://www.apu.mn/sustainable-development?lang=en	GRI 102, SDG 12
MS5.1		Тогтвортой байдлын тайлангал	Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг уу?	Үгүй	Үгүй		COSO ERM, ISO 31000, IEC 31010 стандартын дагуу эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа хэрэгждэг бөгөөд PESTLE, 5 Forces зэрэг макро, микро гадаад орчны нөлөөллийг үнэлэх, нөгөөтэйгүүр дотоод орчноо үнэлэх замаар тогтвортой хөгжлийн стандартад суурилан байгаль орчин, Нийгэм, Засаглалын түвшинд эрсдэлийг үнэлж, тогтвортой хөгжлийн тайланд эрсдэлийн үйл ажиллагааг тусгаж тайлагнадаг. 2025 оноос эхлэн ISSB S2 стандартын дагуу тайлагнах ажлууд хийгдэхээр төлөвлөж байна.	GRI 102, SDG 12
MS5.2		Гшүүнчилэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?	Тийм	Тийм		Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо	GRI 102, SDG 17
Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд								
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	-	MNT 7,257,317,078.80	Mega Втц '000	Эрчим хүчний гол эх үүсвэрүүд нь төвийн эрчим хүчний систем, газ, болон хатуу түлш /нүүрс/ байна. Задаргааг доорх мэдээллүүдээс харна уу.	GRI 302, SDG 12
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	Цахилгааны нийт хэрэглээ - 9,449.545; Хэмнэлтийн хэмжээ - 66.528	Нийт зарцуулалт - 22588.1066 Хэмнэлт - 93.5098	Mega Втц '000	2023 онд тайлагнасан дүн нь зөвхөн Төв АПУ үйлдвэрийн хэрэглээ байсан ба 2024 онд АПУ группийн хэмжээнд тайлагнасан болно. СББ ХХК-ийн хувьд 90 kW хөдөлгүүрүүд дээр инвертор суурилуулсан, гэрэлтүүлгүүдийг LED гэрэлтүүлгээр сольж 29000 кВтц хэмнэлт үүсгэсэн. Төв АПУ үйлдвэрийн хувьд 10 кВт-ын нарын систем суурилуулан 1160.8 кВтц-ийн хэмнэлт, хийн компрессорын даралтыг бууруулж тохиргоо хийсэн 42920 кВтц, технологийн ус түгээх системийн цахилгааны хэрэглээнд дүн шинжилгээ хийж 6241 кВтц хэмнэлт үүсгэсэн. "Шар айрагны үйлдвэр 2" -ын хийн компрессорын эрчим хүчний хэрэглээг бууруулан 14188 кВтц хэмнэлт. Ингээд группийн хэмжээнд нийт 93509.8 кВтц -ийн хэмнэлт үүсгэсэн байна.	GRI 302, SDG 12
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	Зарцуулалт 51877.93; Хэмнэлт 3631.46	Зарцуулалт 59,995.36, Хэмнэлт 3487.3	BTU & % Гкал	Шинэ пивоны үйлдвэрийн уурын конденсацыг ашиглан халаалтын хэрэглээг хангаж дулааны хэмнэлтийг бий болгосон, дулааны үзэлийн тоноглолд засвар үйлчилгээ хийж автоматжуулснаар дулааны хэрэглээг бууруулсан ба цаашид үйлдвэрүүдийн хаягдал конденсацыг ашиглан хэмнэлт хийхээр зорин ажиллаж байна.	GRI 302, SDG 12
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	10,000	1,221,943	Литр/кг & %, ГЖоуль, Төгрөг	2023 оны тайлагнасан дүн нь СББТ компанийн сарын хэрэглээ байсан бол 2024 онд тайлагнасан дүн нь АПУ Трайдинг болон СББ Трайдинг-ийн жилд нийт зарцуулсан түлшний дүн болно. Гайхам ХХК-тай хамтран түлш хэмжигч төхөөрөмж нийт 115 машинд суурилуулсан. Үүнээс СББТ ХХК-ийн 43 машинд 2024 оны 12 сараас эхлэн хэмжилтийг хийж эхлэлээ.	GRI 302, SDG 12
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	100	99.99	%	Төвийн эрчим хүч	SFRD
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	-	0.01	%	2024 онд туршилтын байдлаар 10 кВт-ын нарын систем суурилуулан пивоны шил савны хэсгийн гэрэлтүүлэг ашиглаж байна.	GRI 302, SDG 7

E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгарулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	-	404,695.41	CO2e/тонн	Хүлэмжийн хийг тооцоолохдоо бид дараах хоёр олон улсын стандартад үндэслэсэн: GHG Protocol-ын "Scope 3 ялгарлыг тооцоолох техникийн гарын авлага (version 1.0)" болон ISO 14064-1 (Part 1) стандарт. GHG Protocol-ын гарын авлагыг ашиглан нийлүүлэлтийн сүлжээний (Scope 3) ялгарлыг 15 ангиллаар ангилан, тус бүрт тохирсон аргачлалын дагуу тооцоолон хийсэн. Харин ISO 14064-1 стандартын дагуу байгууллагын түвшний (Scope 1, 2, 3) нийт ялгарлыг тооцох, бүртгэх, тайлагнах зарчмуудыг баримтлан, гоон өгөгдөл цуглуулах, ялгарлын эх үүсвэр тодорхойлох, тайлагналын хил хязгаарыг тогтоох зэрэгт ашигласан. Ингэснээр олон улсын жишигт нийцсэн, ил тод тооцооллыг гүйцэтгэн, гуравдагч байгууллагаар баталгаажууллаа. Дэлгэрэнгүй Тогтвортой хөгжлийн 2024 оны жилийн тайлангаас харна уу.	GRI 305, SDG 13, WRWBCSD GHG protocol
E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жижээр)	-	-	CO2e/тонн	2008–2012 онд байгууллагын тээврийн хэрэгслийн дундаж насжилт 15 жил байсан бол, 2019–2024 онд үе шаттайгаар нийт хөдлөх бүрэлдэхүүний 45%-ийг парк шинэчлэлт хийж, дундаж насжилтыг 8 жил болгон бууруулсан. Үүний үр дүнд түлшний зарцуулалт багасч, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах суурь нөхцөл бүрдсэн. 2024 оны байдлаар 2 ш BYD T3 цахилгаан автомашиньг түгээлтэд, 47 цахилгаан сэрээт ачигчыг агуулахад ашиглаж байна. Цаашд парк шинэчлэлт хийх замаар хүлэмжийн хийн ялгарлыг улам бууруулах зорилт тавин ажиллаж байна.	GRI 305, SDG 13, WRWBCSD GHG protocol
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гаднын төслийг дэмжих гэх мэт) бууралт	1500 шинэс мод	1600 хайлаас мод	ширхэг	Бид жил бүр хамт олноороо мод тарьдаг уламжлалтай бөгөөд 2024 оны хувд УБ хотын СКД-т байршилтай "Инчон мөрөөдлийн төгөл" буюу хуучин хойын цэг байсан байршилд 1500 хайлаас мод тарилаа.	GRI 305, SDG 13, WRWBCSD GHG protocol
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Үгүй	Үгүй		Компанийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бие даасан журам байхгүй боловч ТУЗ-н тогтоолоор батлагдсан "Бизнесийн ёс зүйн дүрэм"-н "Нийлүүлэгчийн дүрэм"-д тусгагдсан байдаг. Нийлүүлэгчийн дүрмийн 4 гол зарчмын нэг нь "Дэлхийд нөлөөлөх нөлөөллийг багасгах" бөгөөд энэ зарчмын агуулгад уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах хүрээнд баримтлах бодлогыг тодорхойлсон. ХАБЗАБО-ны албаны хариуцагч ISO140001-д холбогдох журмууд мөн хамгаарч болох юм. Мөн Хямралын удирдлагын гарын авлага болон Тусгайлан 4 чиглэлд Бизнесийн тасалдалгүй ажиллагсааны төлөөлөгчөөг бөгөөд үүний нэг нь Байгалийн гамшиг болон үйлдвэрийн осол, хүн малын гоц халдаарт өвчний үед хэрэгжүүлэх төлөвлөгөө байдаг.	GRI 201, TCFD, SDG 13
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү?(сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Үгүй	Үгүй		Үлралд бүр PESTLE, 5 forces, SWOT шинжилгээг хийж эрсдэлийг тодорхойлж, үнэлдэг бөгөөд тус шинжилгээнд уур амьсгалын өөрчлөлтийн ерөнхий трендийг судалж, Монгол улсад нөлөөлөх нөлөөлөл болон цаашлаад компанийн зорилгод учрах эрсдэл болон боломжийн үйл ажиллагааны үр дүнд байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх болох эрсдэлийг үнэлж TCF эрсдэлийн тайлангад тусгаж, ТУЗ-д танилцуулдаг. 2025 оноос эхлэн чиг үүргийн дагуу уур амьсгалын эрсдэлийг тодорхойлохдоо сценарь шинжилгээ, стресс тест хийхээр төлөвлөж байна.	GRI 201, TCFD, SDG 13
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	Тийм	Үгүй	Төгрөг	2024 онд групп компанийн хэмжээнд байгалийн гамшаас шууд шалтгаалсан бодит хохирол бүртгэгдээгүй байна. Харин 2024 оны зун УБ хотын захиргааны хүсэлтээр Дунд голын үерээс урьдчилан сэргийлэх зорилгоор компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд 64 сая төгрөг зарцуулж Дунд голын 800 метр зурвас газрын бургасыг чөлөөлөх, лаг халшаасыг цэвэрлэх голын урсац сайжруулах ажлыг гэрээлэгч компаниудаар гүйцэтгүүлсэн.	GRI 201, TCFD, SDG 13
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	1,595,914,488	114,539,656.00	Төгрөг	2024 онд нарны панел худалдаж авахад зарцуулсан хөрөнгө оруулалтын дүн	GRI 201, TCFD, SDG 13
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон үү?	Үгүй	Үгүй		Байгалийн гамшаас үүдэлтэй эрсдэл нь ихэвчлэн хүлээн зөвшөөрөх эрсдэлээр бүртгэгддэг, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан түүхий эд материалын нийлүүлэлт тасалдах, хил гааль хаах гэх мэтээр материалын үнэ өсөх эрсдэлтэй байвал худалдан авалтын төлөвлөгөөг оновчтой замаар урьдчилан захиалах байдлаар ажиллаж байна. Мөн борлуулалтын үйл ажиллагаа удааширч тохиолдлууд байдаг ч агуулахын оновчтой удирдлагыг хэрэгжүүлэх замаар мөн шийдвэрлэдэг. Тухайлсан абаацад тодорхойлсон эрсдэлээ хариуцуулж, эрсдэлийг бууруулах тал дээр арга хэмжээ авч ажилладаг. Үүнээс гадна жилд 2 удаа 1:1 үзлэлтүүдийг хийж, тодорхойлсон эрсдэл дээр зөвлөгөө өгөх, эрсдэлийг бууруулах тал дээр төлөвлөгөө гарган хамтран ажиллаж байна.	GRI, SASB, World Economic Forum

E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	370,257	924,107	м3/л	2023 оны ашигласан усны хэмжээ нь зөвхөн АПУ Төв үйлдвэрийн ашигласан усны хэмжээ байсан бол 2024 оны тоо нь АПУ группийн хүрээнд нийт ашигласан усны хэмжээ болно.	GRI 303, SDG 6
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	15,056	17,658	м3/л	Ус ундаа болон "Шар айралны үйлдвэр-2"-ын хаягдал усыг тус тус дахин ашиглаж байна.	GRI 303, SDG 6
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	-	1.9	%	Нийт усны хэмжээнд дахин ашигласан усны хэмжээг харьцуулсан хувь.	GRI 303, SDG 6
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	-	-	м3/л	Бид 2024 оноос хаягдал бохир ус цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд 2026 онд ашигдалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	GRI 303, SDG 6
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	15,000	150,538.87	тонн	2023 онд бид төв байршил дээрх датгаг хэмжигч тайлалнаж байсан бол энэ жилийн хувьд Хог хаягдлын менежмент дээр илүү анхаарах ажиллан, группийн хэмжээнд ялгаруулсан хог хаягдлын тоон хэмжээг нэгтгэн гаргалаа. Үүнээс дахин ашигласан болон дахин боловсруулсан хог хаягдлын хувь 74.65 байна.	GRI 306, SDG 12
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	66%	74.65%	%	Дахин ашигласан: Хатуу хог хаягдал: 505.11 тн Хүнсний хаягдал: 111,874.77 тн Дахин боловсруулсан (хатуу хог хаягдал): 420.85 тн	GRI 306, SDG 12
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэглэйн хог орно)	7.3	9.36	тонн	Аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөлтэй Түмэн эгшин ХХК болон Элемент медицина ХХК-уудтай хамтран ажиллаж байна.	GRI 306, SDG 12
E6.1		Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	214,328.4 м2	20	%	Үйлдвэрийн бүсэд ногоон байгууламж багатай, оффис нэгж хэсгийн хамрах ногоон байгууламжийг жил бүр засаж сайжруулж, зүлэгжилт, ландшафтын ажлууд хийгддэг	GRI 304, SDG 15
E6.2	Биологийн олон янз байдал	Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо	Үгүй	Үгүй	Төрөл зүйлийн тоо	Суурьшлын бүсэд байдаг тул энэ төрлийн хамгаалах ажил хийж хэрэгжүүлээгүй.	GRI 304, SDG 15
E6.3		Биологийн олон янз байдлаас сөрөгөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээслэсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	Үгүй	Үгүй	%	Суурьшлын бүсэд байдаг тул энэ төрлийн хамгаалах ажил хийж хэрэгжүүлээгүй.	SFRD, IFC Performance Standard 6
Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд								
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	21	20.6	%		GRI 401, SDG 8
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цалин ажлын байрны тоо	178	-	Тоо	2024 онд бүтцийн өөрчлөлт хийгдээгүй, шинээр орон тоо нэмээгүй болно.	GRI 401, SDG 8
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	5.53	12.3	цаг		GRI 401, SDG 8
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЗА)	ХАБЗА-н бодлого	ХАБЗА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" гэх мэт группийн хэмжээнд нийтдээ 14 журмыг чанд мөрдөн ажиллахын зэрэгцээ Heineken-ий ХАБЗА-н "Амь насдаа хамгаалах 12 амлалт"-ыг мөрдлөг болгон ажилладаг. https://www.theheinekencompany.com/sites/heineken-com/files/heineken-com/sustainability-and-responsibility-four-principles/our-policies/heineken-life-saving-commitments.pdf	GRI 103, SDG 10
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	0.1 тоо/жилээр	-	%	2024 онд АПУ компанийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалт тогтоогдсон осол 200,000 хүн цаг тутамд 0.0 гэсэн үзүүлэлттэй байна. 2024 онд групп компанийн хэмжээнд ХАБЗА-н чиглэлээр "Аюулгүй ажиллагааны компани ажлууд", "Сэрээт өргөмчийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр", "Аюулгүй жолоодлогын манлайлагч" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн.	GRI 403, SDG 3
S2.3		ХАБЗА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЗА сургалтын цаг	16.5	6.3 /Танхимын сургалт/	цаг	2024 онд компанийн хэмжээнд ХАБЗА-н танхимээр сургалт нэг ажилтанд 6.3 хүн цаг ноогдож байна. Ажилтны цахимээр болон ажлын байр дээр биетэр авсан сургалт, дадлага, зааварчилгааны цагийг оруулж тооцогүй болно.	GRI 403, SDG 3
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	9878	9348	хүн	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хувьд 9348 хүнд /ханиад томуу, артерийн даралт ихсэх өвчин, анхны тусламж, яаралтай тусламж, дуудлага бусад / зөвлөгөө өгч эрүүл мэндийн тусламж үзүүлэв. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний хувьд Хүнсний үйлдвэрийн ажилчдын зайлшгүй шинжилгээнд АПУ ХК 2 удаа нийт 700 ажилтан, АПУ Дайри ХХК 2 удаа 420 ажилтан хамруулж 100% гүйцэтгэлтэй хамруулав. Мөн ХӨСҮТ –тэй хамтран халдварт өвчний эрт илрүүлэг хийж өөрчлөлттэй гарсан ажилтанд зөвлөгөө өгч, шаардлагатай ажилтан дараагийн шатлалын эмнэлэг рүү илгээв. Анхны болон яаралтай тусламжийн хувьд 215 удаагийн давтагдсан дуудлага хүлээн авч, 25 ажилтанд яаралтай тусламж үзүүлэв.	GRI 403, SDG 3

S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		Хөдөлмөрийн дотоод журмын 18-р бүлэг. Хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх тухай заасан байдаг.	GRI 405, SDG 5
S3.2		Ахлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		АПУ ХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан Бизнесийн ёс зүйн дүрмийн нэг бүрдэл болох "Хүний эрхийн бодлого" -д багтсан хүний эрхийн стандартуудын нэг нь "дарамт үзүүлэхгүй болон хүчирхийлэхгүй байх" стандарт байдаг. Мөн Хөдөлмөрийн дотоод журмын 19-р бүлэг. Ахын эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас ангид байх тухай заасан байдаг.	GRI 103, SDG 5
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм		АПУ ХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан Бизнесийн ёс зүйн дүрмийн нэг бүрдэл болох "Хүний эрхийн бодлого" -д багтсан хүний эрхийн стандартуудын нэг нь "үл ялгаварлах" стандарт байдаг. Мөн Хөдөлмөрийн дотоод журмын 17-р бүлэг. Олон талт ялгаатай байдлыг хүндлэх тухай, 18-р бүлэг. Хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх тухай тус тус заасан байдаг.	GRI 103, SDG 10
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эрэгтэй 62% Эмэгтэй 38%	Эрэгтэй 60.9% Эмэгтэй 39.1%	%		GRI 405, SDG 5
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	-	Эрэгтэй 89% Эмэгтэй 11%	%		GRI 405, SDG 5
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эрэгтэй 58% Эмэгтэй 42%	Эрэгтэй 71.4% Эмэгтэй 28.6%	%		GRI 405, SDG 5
S3.7		Дүнд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дүнд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эрэгтэй 66% Эмэгтэй 34%	Эрэгтэй 61.2% Эмэгтэй 38.8%	%		GRI 405, SDG 5
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	-2.7%	-3.9%	харьцаа	Эрэгтэй ажилтнуудын цалинг эмэгтэй ажилтнуудынхтай нийтэд нь харьцуулбал 3.9-өөр бага, энэ нь ахлын байрны төрөл, онцлогоос шалтгаалж байна.	GRI 405, SDG 5, SFRD
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	-	Тийм		Хөдөлмөрийн дотоод журмын 17-р бүлэг. Олон талт ялгаатай байдлыг хүндлэх тухай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай заасан байдаг.	SDG 10
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	1.8	1.6	%	АПУ ХК-1.67, АПУ Трейдинг-1.97, СББ Трейдинг-1.41, МБС-1.89, АПУ Дэйри-0.95	SDG 10
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	10	Тийм		АПУ компанийн 296 ажлын байранд үнэлгээ хийгдэж, тэр дотроос хурдан хугацаанд тохируулга хийх боломжтой 10 ажлын байрыг сонгон авч, ажлын байрны тохируулгуудыг шат дараатай хийж бэлэн болсон ажлын байрыг нээлттэй ажлын байрны зар болон иргэний нийгмийн ажилтнуудад мэдээлэл түгээж сонгон шалгаруулалтыг хийж байна.	SDG 10
S4.4		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо	-	-	Terper	Зөрчил торгууль аваагүй.	SDG 10
S5.1	Нийгмийн хариуцлага ба ил тод байдал	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	Тийм	Тийм		"Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого" https://www.apu.mn/investors-rules?lang=	IFC
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компанийн нийгэмд нөлөөлөл байдлын бодлого, журамтай юу? (Гүнд газар чөлөөлөлт багтана)	-	Тийм		Группийн хэмжээнд нэгдсэн бодлого одоогоор байхгүй ч АПУ Дэйри ХХК-ийн үйл ажиллагаанд "Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл байдлын түргэвчилсэн үнэлгээ хийх журам" болон "Газар чөлөөлөл, нүүлгэн шилжүүлэх журам"-ыг 2024 онд батлан, хэрэгжүүлж байна.	IFC Performance Standards
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	Тийм	Тийм		"Харилцагч, хэрэглэгчийн санал гомдол шийдвэрлэх журам" нь бүтээгдэхүүн үйл ажиллагаатай холбоотой харилцагч хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэхэд оршино.	GRI 102, SDG 16
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм	Тийм		Бид компанийнхаа www.apu.mn вебсайтаар дамжуулж аливаа мэдээ мэдээллийг түгээдэг бол манай бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой хэрэглэгч, харилцагч нарын санал хүсэлт, гомдол мэдээллийг 70071111 утсаар авч, Харилцагчийн удирдлага, хамтын ажиллагааны албатай холбогдох шийдвэрлүүлдэг. Ес зүйн зөрчил, аливаа зүй бус үйлдлийн талаарх мэдээллийг www.apu.mn вебсайтын "Шугал утсаа" цэсэнд хандаж мэдэгдэж шийдвэрлүүлдэг. Бусад өргөдөл, гомдлыг бичиг хэргийн ажилтанд хандан шийдвэрлүүлэх боломжтой.	IFC Performance Standards
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	100	100	%	Тухай бүрт нь шийдвэрлэн ажилладаг.	GRI 413, SDG 8

S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь	-	-	%	Нийгмийн хариуцлагын чиглэлээр хийсэн ажлуудыг Үйл ажиллагааны жилийн тайлан болон Тогтвортой хөгжлийн жилийн тайланд тусгасан бөгөөд АПУУ ХК нь залуус, иргэдийн эрүүл мэнд, чөлөөт цагийг дэмжих зорилгоор спорт, соёлын үйл ажиллагааг тогтмол ивээн тэтгэн ажиллаж байна. Үүнд Парис 2024 олимпын, паралимпийн шууд дамжуулалт, Үндэсний дээд лиг, FC Ulaanbaatar багийн үйл ажиллагаа, Монгол бөхийн өргөөний баригдаанууд, соёлын өвийг хамгаалах хөтөлбөрүүд зэрэг багтана.	GRI 413, SDG 8
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	-	Тийм		"Баруу, ажил үйлчилгээ худалдан авалтын журам" гэж байдаг, уг журмын 6.1 заалтад Компани нь зөвхөн бизнесийн ёс зүйн зарчим бүхий байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг, хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, үйл ажиллагаа явуулах эрхийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөлтэй, санхүүгийн чадавхи бүхий аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнтэй хамтран ажиллана гэж заасан байдаг.	GRI 204, SDG 8
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь		30	%	Нийт худалдан авалтын үнийн дүнгийн 30 орчим хувийг дотоодын бэлтгэн нийлүүлэгч нараас худалдаж авч байна.	GRI 204, SDG 8
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	АПУУ ХК - 4, АПУУ Дайри ХХК - 0.1	11	%	Үйл ажиллагаандаа ISO стандарт хэрэгжүүлсэн 60 орчим ханган нийлүүлэгч байдгаас ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцооны стандарт нэвтрүүлсэн нийлүүлэгчдийн тоо 22 байна.	GRI 204, SDG 8
Засаглалын шалгуур үзүүлэлтүүд								
G1.1	Компанийн засаглал	Авлигын эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм	Тийм		https://www.apu.mn/wp/wp-content/uploads/2023/04/3-%D0%90%D0%B2%D0%BA%D0%B8%D0%B3%D1%8B%D0%BD-%D0%B1%D0%BE%D0%B4%D0%B8%D0%BE%D0%B3%D0%BE.pdf	GRI 205, SDG 16
G2.1		Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	33	33	%	Компанийн тухай хуудийн 75.4-д заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийн 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байх шаардлагыг хангаж байна.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.2		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм	Тийм		Компанийн дүрэм болон Компанийн засаглалын дүрэм, журмуудаар хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалдаг. https://www.apu.mn/investors-rules/?lang=	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G2.3	Комплаенс	Компанийн засаглалын бодлого, журам	Компанийн засаглалын бодлого, журам бий юу?	Тийм	Тийм		https://www.apu.mn/investors-rules/?lang=	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.1		Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?	Тийм	Тийм		https://www.apu.mn/wp/wp-content/uploads/2024/01/23_19a_Compliance-guidelines_mon.pdf	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдлага, хориг гэх мэт) бий юу?	Тийм	Тийм		Бизнесийн ёс зүйн дүрмийн Шүтэл үлээх бодлого, Ашиг сонирхлын зөрчлийн бодлого, Мөнгө угаахтай тэмцэх болон хориг арга хэмжээний бодлого, журмаар зохицуулдаг. https://www.apu.mn/wp/wp-content/uploads/2023/04/10_COCB_combined_mon.pdf	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамраах салбарын асуултуудыг бөглөнө үү)								
A1	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Устгалын бодис /pesticide/	Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?	N/A	N/A			GRI 403, SDG 12
A2		Тогтвортой газар, бэлчээр	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчлэн стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь	N/A	N/A	%		SDG 12
A3		Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь	0	0.03	%	АПУУ ХК, М-Би-Си Азия Пасифик ХХК, Спирт Бал Бурам ХХК, СЕБ Трейд ХХК, АПУУ Трейднэг ХХК-ын хэмжээнд хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй зах зээлээс татан авсан бүтээгдэхүүн 2024 онд гараагүй. Худалдах боломжгүй болсон дотооддоо устгасан бүтээгдэхүүний тоог оруулан тооцоолов.	GRI 416, SDG 12
MA1	Боловсруулалт	Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам	Тийм	Тийм		"Химийн бодисын хяналтын журам"-ыг 2011 оноос үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн бөгөөд 2017 онд сүүлд өөрчлөлт оруулсан байна. Уг дотоод журмаар Химийн хортой болон аюултай бодисыг аних, буулгах, тээвэрлэхэд тавигдах шаардлага, хадгалах заавар, ашиглах ерөнхий зарчим зэргийг нарийвчлан зааж өгсөн болно.	GRI 403, SDG 12
MA2		Дахин боловсруулсан материал	Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь	52	34	%	Эргэлтээр дахин ашиглагддаг лонхтой бүтээгдэхүүний борлуулалтын дүнтэй харьцуулахад 34%-г эргүүлэн татаж дахин ашигласан байна. Өмнөх оноос татан авалтын хувь буурсан шалтгаан нь Ерөөл болон Grandkhan original брэндүүдийн үйлдвэрлэлийг зогсоосонтой холбоотой шилний татан авалтыг мөн зогсоосон.	SDG 12
MA3		Ногоон шошго, гэрчилгээхүүссэн байдал	Энэ буюу ногоон шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний эзлэх хувь	6	0.8	%	АПУУ Дайри ХХК-ийн үйлдвэрлэл буй Mont Yak брэндийн шар тос болон 3 төрлийн хайлмаг нь "Органик бүтээгдэхүүний тухай хууль"-ийн шаардлагыг хангаж "Органик бүтээгдэхүүн" гэрчилгээг авсан бөгөөд АПУУ Дайри ХХК-ийн нийт бүтээгдэхүүн борлуулалтын 0.8%-ыг эзлэж байна.	GRI 417, SDG 12

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

100 YEARS



АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот - Т7040, Чингисийн өргөн чөлөө - 14

Утас: +976 - 76002220, +976 - 11 - 343063

www.apu.mn